



Замын хөдөлгөөний нэгдсэн бодлого, эрх зүйн зохицуулалт дутмаг, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөг мөрдөөгүй, зөрчиж шийдвэр гаргадаг, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж замын хөдөлгөөний ачаалал буурахгүй байна.



**Улаанбаатар хот  
2022 он**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/25.

Улаанбаатар хот






Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн замын хөдөлгөөний бодлого, төсвийн зарцуулалтын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2022/46-ШТА-ГА/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар) -д зөвлөсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.
4. Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

|                                                                                                                                                                                                                                                         |                                                                                         |       |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|-------|
| <b>Аудитын тайланг бэлтгэсэн:</b>                                                                                                                                                                                                                       | Товчилсон үг                                                                            | 3-4   |
| Нийслэл дэх Төрийн аудитын газар. Гүйцэтгэл-нийцлийн хэлтэс                                                                                                                                                                                             | Хүснэгтийн жагсаалт                                                                     | 4     |
|                                                                                                                                                                                                                                                         | Графикийн жагсаалт                                                                      | 4     |
|                                                                                                                                                                                                                                                         | Дүрслэлийн жагсаалт                                                                     | 4-5   |
| Хэлтсийн дарга, аудитын менежер<br> Э.Мөнхмандах<br>Аудитын менежер<br> Б.Номинбаатар | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл                    | 6     |
|                                                                                                                                                                                                                                                         | БҮЛЭГ А. Нийслэлийн замын хөдөлгөөний бодлого үр дүнтэй байна уу?                       | 7     |
|  Л.Саранбаатар<br>Ахлах аудитор                                                                                                                                        | 1.1 Нийслэлийн замын хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт оновчтой байна уу?                | 8-13  |
|  Ж.Жавзанпагма<br>Аудитор                                                                                                                                              | 1.2 Бодлогын баримт бичиг хоорондын уялдаа хангагдаж байна уу?                          | 13-14 |
|  Д.Дайриймаа<br> Г.Чулуунцэцэг                                                       | 1.3 Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт хангагдсан уу?                          | 14-25 |
|  З.Болд<br> З.Баярбилэгт                                                          | БҮЛЭГ Б. Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт, түүнд зарцуулсан үр дүнтэй байна уу? | 26    |
|  О.Оргил                                                                                                                                                             | 2.1 Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт үр дүнтэй байна уу?                        | 26-41 |
|  Б.Золбаяр<br> Б.Батбилгүүн                                                       | 2.2 Нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулахад батлагдсан хөрөнгө үр дүнтэй байна уу?   | 41-51 |
| Гэрээт ажилтан<br> Д.Болормаа                                                                                                                                        | Аудитын дүгнэлт                                                                         | 52    |
|                                                                                                                                                                                                                                                         | Аудитын зөвлөмж                                                                         | 53    |
| Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус. Утас: 327787                                                                                                                                                                                 | Холбогдох байгууллагын санал                                                            | 54    |
|                                                                                                                                                                                                                                                         | Саналд өгсөн тайлбар                                                                    | 55    |
| Тайланг <a href="https://audit.mn/">https://audit.mn/</a> веб сайтаас үзнэ үү.                                                                                                                                                                          |                                                                                         |       |

Товчилсон үг

|              |                                                                                          |
|--------------|------------------------------------------------------------------------------------------|
| ААНБ         | Аж ахуйн нэгж, байгууллага                                                               |
| АХБ          | Азийн хөгжлийн банк                                                                      |
| АЗТХ         | Авто замын тухай хууль                                                                   |
| АТТХ         | Авто тээврийн тухай хууль                                                                |
| БТХ          | Барилгын тухай хууль                                                                     |
| БГД          | Баянгол дүүрэг                                                                           |
| БЗД          | Баянзүрх дүүрэг                                                                          |
| БНХАУ        | Бүгд найрамдах Хятад ард улс                                                             |
| БНФУ         | Бүгд найрамдах Франц улс                                                                 |
| БХБЯ         | Барилга хот байгуулалтын яам                                                             |
| ГЗБГЗЗГ      | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар                                        |
| ГТХ          | Газрын тухай хууль                                                                       |
| ЕБС          | Ерөнхий боловсролын сургууль                                                             |
| ЕХОБ         | Европын хөрөнгө оруулалтын банк                                                          |
| ЕСБХБ        | Европын сэргээн босголтын хөгжлийн банк                                                  |
| ЗХЗХШЖ       | Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам                                           |
| ЗХАБТХ       | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль                                            |
| ЗХУТ         | Замын хөдөлгөөний удирдлагын төв                                                         |
| ЗТХ          | Зөрчлийн тухай хууль                                                                     |
| НЗХТЗИГ      | Нийслэлийн замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар                |
| ИШС          | Инженер, шугам, сүлжээ                                                                   |
| МУЗГ         | Монгол Улсын Засгийн газар                                                               |
| МУНУБХЭЗБТХ  | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль                      |
| МУЗЗНДНТУТХ  | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль        |
| МУИГӨТХ      | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль                                          |
| МУҮХ         | Монгол Улсын үндсэн хууль                                                                |
| МУЗХД        | Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм                                                     |
| НБГ          | Нийслэлийн Боловсролын газар                                                             |
| НЗДТГ        | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар                                                     |
| НЗД          | Нийслэлийн Засаг дарга                                                                   |
| НИТХ         | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал                                                  |
| ННТГ         | Нийслэлийн Нийтийн тээврийн газар                                                        |
| НХОГ         | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар                                                      |
| НЗХГ         | Нийслэлийн Замын хөгжлийн газар                                                          |
| НЗСХ         | Нийслэлийн Замын сангийн хөрөнгө                                                         |
| НГЗБА        | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба                                                |
| НӨТҮГ        | Нийслэлийн өмчит төсөвт үйлдвэрийн газар                                                 |
| НУБХАЗТБНТХН | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж |
| НТХО         | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт                                                      |
| НЭЗТТХЗШТСЖ  | Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам    |
| ОАТТХ        | Онцгой албан татварын тухай хууль                                                        |
| ОНӨТҮГ       | Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар                                               |
| ОНӨААТҮГ     | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                     |
| ОНХС         | Орон нутгийн хөгжлийн сан                                                                |
| СБД          | Сүхбаатар дүүрэг                                                                         |
| СӨБ          | Сургуулийн өмнөх байгууллага                                                             |
| СХД          | Сонгинохайрхан дүүрэг                                                                    |
| ТАХ          | Төсөл, арга хэмжээ                                                                       |
| ТББ          | Төрийн бус байгууллага                                                                   |
| ТЦА          | Тээврийн цагдаагийн алба                                                                 |
| ТЭЗҮ         | Техник, эдийн засгийн үндэслэл                                                           |
| ТХХХТЖ       | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам                                 |
| ТӨХК         | Төрийн өмчит хувьцаат компани                                                            |
| УБЗАА        | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба                                                 |
| УИХ          | Улсын Их хурал                                                                           |
| УТХӨ         | Улсын төсвийн хөрөнгө оруулалт                                                           |
| УБДС         | Улаанбаатар дулааны сүлжээ                                                               |
| УБЦТС        | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ                                                      |
| УСУГ         | Ус сувгийн удирдах газар                                                                 |
| ХХМТГ        | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар                                            |
| ХТСИ         | Хот төлөвлөлт судалгааны институт                                                        |

|          |                                                                  |
|----------|------------------------------------------------------------------|
| ХСХГ     | Хотын стандарт, хяналтын газар                                   |
| ХБТХ     | Хот байгуулалтын тухай хууль                                     |
| ХБХГ     | Хот байгуулалт, хөгжлийн газар                                   |
| ХСГДХТХ  | Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль                    |
| ХБТТУТХ  | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль       |
| ХСОАБХЗГ | Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар |
| ХБТТУТХ  | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль       |
| ХУД      | Хан-Уул дүүрэг                                                   |
| ЧД       | Чингэлтэй дүүрэг                                                 |

#### Хүснэгтийн жагсаалт

|            |                                                                                                        |       |
|------------|--------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| Хүснэгт 1  | УИХ, НИТХ-аас баталсан бодлогын баримт бичгүүд                                                         | 7     |
| Хүснэгт 2  | Эрх зүйн зохицуулалт, арга хэмжээ                                                                      | 10    |
| Хүснэгт 3  | Зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгсэл                                                                      | 11    |
| Хүснэгт 4  | Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалтын талаар тусгагдсан арга хэмжээ                               | 15-16 |
| Хүснэгт 5  | НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжилт                                                             | 22    |
| Хүснэгт 6  | ЗХУТ-өөс илрүүлсэн зөрчил, торгуулийн мөнгөн дүн                                                       | 29    |
| Хүснэгт 7  | Нийтийн тээврийн автобусны мэдээлэл                                                                    | 30-31 |
| Хүснэгт 8  | Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:1 “5 шар- Офицеруудын ордон” чиглэлийн ашиглалтын хурдны судалгаа      | 36    |
| Хүснэгт 9  | Нийслэлийн ЕБС-ийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй автобусны тоо, түүний насжилт                   | 37    |
| Хүснэгт 10 | 2013-2021 онд олгосон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ                                             | 39    |
| Хүснэгт 11 | Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний зориулалт                                                      | 39-40 |
| Хүснэгт 12 | 2012-2021 онд төлөвлөсөн сургууль, цэцэрлэгийн тоо                                                     | 42    |
| Хүснэгт 13 | 2012-2021 оны хугацаанд Замын салбарт гаргасан ТАХ-ний мэдээлэл                                        | 43    |
| Хүснэгт 14 | 2022 оны Нийслэлийн төсвийн авто замын түгжрэл бууруулах ТАХ-ний газар чөлөөлөлтийн мэдээлэл (тоогоор) | 44-45 |
| Хүснэгт 15 | Сургууль, цэцэрлэгийн байршил                                                                          | 45    |
| Хүснэгт 16 | Улс, нийслэлийн хөрөнгөөр 2012-2021 онуудад гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр ажилласан ТАХ-үүд           | 46-47 |
| Хүснэгт 17 | НЗС болон бусад эх үүсвэрээс 2012-2021 онуудад гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр ажилласан ТАХ-үүд        | 47    |
| Хүснэгт 18 | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2012-2021 онуудад санхүүжигдэн бүрэн ашиглалтад орсон ТАХ-үүд        | 47-48 |
| Хүснэгт 19 | Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-ний олгогдсон нийт санхүүжилт                              | 49    |

#### Графикийн жагсаалт

|           |                                                                                                                                              |    |
|-----------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| График 1  | Дутуу хэрэгжсэн арга хэмжээ                                                                                                                  | 24 |
| График 2  | Нийтийн тээврийн насжилт                                                                                                                     | 31 |
| График 3  | Нийслэлийн төвийн 6 дүүргийн ЕБС-ийн хамран сургах болон хамран сургах бус тойргийн суралцагчдын мэдээлэл                                    | 31 |
| График 4  | ЕБС-д элссэн болон төгсөгчдийн харьцаа                                                                                                       | 32 |
| График 5  | 2012-2021 онд шинээр баригдсан сургуулийн тоо                                                                                                | 32 |
| График 6  | 2015-2022 онд СӨБ-д элсэн суралцаж буй хүүхдүүдийн мэдээлэл                                                                                  | 33 |
| График 7  | 2012-2022 онд газар чөлөөлөлтөд зарцуулсан санхүүжилт                                                                                        | 34 |
| График 8  | Газар чөлөөлөлтийн байдал                                                                                                                    | 35 |
| График 9  | Авто замын зураг төсөв боловсруулах ТАХ                                                                                                      | 36 |
| График 10 | Улсын дугаарын сүүлийн орон тэгш, сондгой болон сүүлийн оронгоор ангилан ажлын өдрүүдэд замын хөдөлгөөнд оролцуулсан тээврийн хэрэгслийн тоо | 37 |
| График 11 | Бүртгэлийн камерт бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо /давхардсанаар/                                                                        | 38 |
| График 12 | 2013-2021 онд 16 давхраас дээш зөвшөөрөл олгосон мэдээлэл                                                                                    | 40 |
| График 13 | Барилгын зөвшөөрлийн эзлэх хувийг зориулалтаар харуулбал                                                                                     | 41 |
| График 14 | ТАХ-ний төсөвт өртгийг зориулалт 2012-2021 он (хувиар)                                                                                       | 42 |
| График 15 | Түгжрэл бууруулах чиглэлээр батлагдсан төсвийн ангилал                                                                                       | 44 |
| График 16 | Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн зориулалт болон хүчин чадлын үзүүлэлт                                                                     | 46 |
| График 17 | Сургууль цэцэрлэгийн барилгын хэрэгжилтийн тоон мэдээ                                                                                        | 48 |

#### Дүрслэлийн жагсаалт

|           |                                           |   |
|-----------|-------------------------------------------|---|
| Дүрслэл 1 | Замын хөдөлгөөн зохицуулах эрх зүйн орчин | 9 |
|-----------|-------------------------------------------|---|

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО,  
ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН

|            |                                                                                                                                                             |    |
|------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Дүрслэл 2  | НЗД-аас гаргасан захирамж, шийдвэр                                                                                                                          | 11 |
| Дүрслэл 3  | МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичиг                                                                                                                   | 15 |
| Дүрслэл 4  | НИТХ-аар баталсан шийдвэрүүд                                                                                                                                | 21 |
| Дүрслэл 5  | НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн залгамж халаа                                                                                                            | 24 |
| Дүрслэл 6  | 2016-2022 онд Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцэх асуудал                                                                                                         | 27 |
| Дүрслэл 7  | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагад төлөвлөгдсөн 2 гол замын нөлөөлөлд өртсөн байдал | 34 |
| Дүрслэл 8  | 2020 онд олгогдсон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ                                                                                                     | 40 |
| Дүрслэл 9  | БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-үүд                                                                             | 49 |
| Дүрслэл 10 | Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 буюу BRT төслийн төлөвлөлтийн зураг                                               | 50 |
| Дүрслэл 11 | “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”                                                                                         | 51 |

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     | <b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1<sup>1</sup>, 4.1.9<sup>2</sup>, 6 дугаар зүйлийн 6.1<sup>3</sup>, 9 дүгээр зүйлийн 9.1<sup>4</sup>, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2022 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Аудитын зорилт</b>                     | <p>Аудитын зорилт: Нийслэлийн замын хөдөлгөөний бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн.</p> <p>а. Нийслэлийн замын хөдөлгөөний бодлого үр дүнтэй байна уу?</p> <p>б. Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт, зарцуулсан хөрөнгө үр дүнтэй байна уу?</p> <p>Аудитад НИТХ, НЗД, ЗДТГ, УБ хотын ЗАА, ТЦА, ЗХУТ, НЗХГ, НБГ, НТҮГ, ХБХГ, НГЗБА, НХОГ, НӨХГ болон бусад харьяа газруудын зарим үйл ажиллагааг 2012-2022 онд хамруулан гүйцэтгэлээ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | <p>Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж, АДБОУС 300, 3000-3100, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, МУЕА-ын 2018 оны А/151 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах заавар, Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх заавар”, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> |
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>       | <p>Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах удирдаж, аудитын менежер Б.Номинбаатар, Л.Саранбаатар нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитын багийг ахлах аудитор Ж.Жавзанпагма ахалж, аудитор Д.Дайриймаа, З.Болд, Г.Чулуунцэцэг, З.Баярбилэгт, Б.Золбаяр, О.Оргил, Б.Батбилгүүн, гэрээт ажилтан Д.Болормаа нар хийж гүйцэтгэсэн.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |

<sup>1</sup> “төрийн санхүү, төсвийн хяналт” гэж төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийхийг;

<sup>2</sup> “гүйцэтгэлийн аудит” гэж шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийхийг;

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.

<sup>4</sup> Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ.

## А. НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:** УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050”, 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх чиг хандлага”, 2012 оны 37, 2016 оны 45, 2020 оны 24 дүгээр тогтоолуудаар МУЗГ-ын /2013-2016, 2016-2020, 2020-2024 он/ үйл ажиллагааны хөтөлбөр баталсан. НИТХ-ын 2013 оны 5/18, 2016 оны 3/08, 2020 оны 02/10 тогтоолуудаар НЗД-ын /2013-2016, 2016-2020, 2020-2024 он/ үйл ажиллагааны хөтөлбөр баталсан.

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг УИХ-аас 2020 онд батлахдаа “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050”-д тусгагдсан тул УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.

### Хүснэгт 1. УИХ, НИТХ-аас баталсан бодлогын баримт бичгүүд

| № | Бодлогын баримт бичиг                                                                                      | Баталсан                                                                                                                                                                                                        | Хэрэгжих хугацаа |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|
| 1 | Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор хүчингүй болсон/             | УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол                                                                                                                                                                               | Хүчингүй болсон  |
| 2 | Алсын хараа-2050                                                                                           | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол                                                                                                                                                                               | 2050 он хүртэл   |
| 3 | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх чиглэл | УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол                                                                                                                                                                               | 2030 он хүртэл   |
| 4 | Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл                                                | УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол                                                                                                                                                                               | 5 жил            |
| 5 | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл                                                  | НИТХ-ын 2020 оны 02/09 дугаар тогтоол                                                                                                                                                                           | 5 жил            |
| 6 | Монгол улсын Засгийн засгийн үйл ажиллагааны хөтөлбөрүүд                                                   | УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол /2013-2016 он/<br>УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол /2016-2020 он/<br>УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол /2020-2024 он/<br>НИТХ-ын 2012 оны 5/18 дугаар тогтоол /2013-2016 он/ | 4 жил            |
| 7 | Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрүүд                    | НИТХ-ын 2016 оны 3/08 дугаар тогтоол /2016-2020 он/<br>НИТХ-ын 2020 оны 02/10 дугаар тогтоол /2020-2024 он/                                                                                                     | 4 жил            |

Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалтын хүрээнд 2012-2021 онд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой 31 зорилт, 152 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнээс 35 буюу 23.0% нь бүрэн хэрэгжсэн байна. Харин 11.8% буюу 18 арга хэмжээний эхлэх хугацаа болоогүй, 28.9% буюу 44 арга хэмжээний дуусах хугацаа болоогүй байна. 23.6% буюу 36 арга хэмжээ хэрэгжилт дутуу, 12.5% буюу 19 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбоотой 2012-2021 оны хэрэгжилтийг аудитад хамруулсан.

Төрөөс авто тээвэр, барилга, төмөр зам гэх мэт салбаруудын бодлогыг баталсан ч замын хөдөлгөөнтэй холбоотой тухайлсан бодлого, чиглэлийг гаргаагүй байна.

Мөн “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт “Нийслэлийн авто зам, Нийтийн тээврийн салбар”-ыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар тусгасан ч одоогийн байдлаар батлагдаагүй байна.

## **1.1 . Нийслэлийн замын хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт оновчтой байна уу?**

Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалтад АЗТХ, ЗХАБТХ, АТТХ болон ЗХЗХШЖ, МУЗХД, ТХХХТЖ, НЭЗТТХЗШТСЖ болон бусад эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Дээрх хууль, журам, дүрмийн хүрээнд нийслэлийн автозамын зохицуулалтыг нийцүүлэн төлөвлөж, мөрдөж байгаа ч өнөөгийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэхгүй, цаг үеийн шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь тодорхой үр дүнд хүрэхгүй, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага бий болжээ.

### **1.1.1.Замын хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?**

#### **Нийслэлийн замын хөдөлгөөний өнөөгийн байдал:**

Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг анх 1954 онд боловсруулж түүнээс хойш 6 дахь ерөнхий төлөвлөгөө буюу УИХ-ын 2013 оны 2 дугаар сарын 8-ний өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх чиг хандлагын баримт бичиг”-ийг мөрдөж байна.

Дээрх төлөвлөгөөгөөр 2030 он хүртэл УБ хотын авто замын сүлжээг хотын барилгажих хэсгийн хилийн цэс дотор 1605.3 км урт болгохоор төлөвлөж 2021 оны байдлаар хотын автозамын сүлжээний нийт урт 779.2 км буюу төлөвлөгөөний хэрэгжилт 46%-тай байна.

Статистик болон нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын мэдээтэй танилцахад дараах үзүүлэлтүүд гарч байна. Үүнд:

- 2012 онд МУ-ын нийт хүн амын 45.9% буюу 1,318,430 нь УБ хотод амьдарч байсан бол 2021 оны байдлаар нийт хүн амын 48% буюу 1,639,172 нь УБ хотод амьдарч, хотын хүн ам жилд дунджаар 3.6%-иар, 2012 онтой харьцуулбал 24.3%-иар өссөн байна.
- МУ-д бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 54.0% буюу 662.644 нь УБ хотод бүртгэлтэй байна. Тээврийн хэрэгслийн тоо жилд дунджаар 15%-иар өсөж, 2012 онтой харьцуулбал 80.1%-иар, 2000 онтой харьцуулбал 14 дахин нэмэгдсэн.
- УБ хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 72.2% буюу 478.500 нь суудлын тэрэг, 2.5% буюу 16.600 нь автобус, 25.3% буюу 167.600 нь бусад тээврийн хэрэгсэл байна. Замын хөдөлгөөнд өдөрт дунджаар 380.0-470.0 мянган тээврийн хэрэгсэл оролцож байна.
- Дунджаар /5 жилийн/ хүн амын 23.8% буюу 389.640 нь нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байна. 2017 оны байдлаар өдөрт дунджаар 480.000 хүн нийтийн тээврийн хэрэгслээр зорчдог байсан бол 2022 оны байдлаар 279.300 зорчигч буюу 5 жилийн өмнөхөөс 58.1%-иар буурсан байна.
- 2012 оны байдлаар нийслэлийн замын хөдөлгөөний ачаалал авдаг гол замууд нь Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Их бага тойруу байсан бол 2022 оны байдлаар УБ хотын гол болон туслах замууд бүгд ачаалалтай болсон байна.
- НЗДТГ-аас нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд авто замын түгжрэлээс үүдэн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд тулгарч буй сөрөг нөлөөллийг судлах, алдагдсан боломжийн өртгийг нарийвчлан тооцох судалгааг “Эм Эм Си Жи” ХХК-аар зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлсэн байна. Энэхүү судалгаагаар замын хөдөлгөөний ачааллаас хамаарч 1 хүн өдөрт 2.5 цаг, жилд 35 өдрийг түгжрэлд өнгөрөөж байна. Мөн автомашин 2.5 цаг түгжрэхэд 3.4 литр шатахуун зарцуулж, 1 литр шатахууныг 2390 төгрөгөөр тооцоход 8365 төгрөг, сард дунджаар 243.780 төгрөгийг түгжрэх цаг хугацааны шатахуунд үргүй зарцуулдаг тооцоо гарч байна.
- БОАЖЯ-ны мэдээгээр нийслэлийн агаарын бохирдлын 10%-ийг автомашины утаа эзэлдэг. Замын хөдөлгөөн хэт ачаалалтай үед автомашин 2 цаг түгжрэхэд 3.5 литр

шатахуун зарцуулж 879-909 гр хорт бодис ялгаруулдаг энэ нь агаар орчныг бохирдуулдаг байна.

### **Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөнийг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт:**

Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалтад АЗТХ, ХБТХ, ЗХАБТХ, АТТХ, МУЗЗНДТУТХ, МУНУБХЭЗБТХ болон ЗХЗХШЖ, МУЗХД, ТХХХТЖ, НЭЗТТХЗШТСЖ холбогдох стандарт, дүрэм, журмууд мөрдөгдөж байна.

#### **Дүрслэл 1. Замын хөдөлгөөн зохицуулах эрх зүйн орчин**



АЗТХ, ЗХАБТХ, АТТХ-иудаар замын хөдөлгөөний аюулгүй байдал, авто замыг төлөвлөх, барих, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах, авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон авто тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, авто тээвэрлэлт болон авто тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг, харин холбогдох стандарт, дүрэм журмуудаар замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, түгжрэлтэй холбоотой цаг үеийн шинжтэй харилцааг нарийвчлан зохицуулж байна.

Хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

1. АЗТХ-ийг 2017 онд шинэчлэн батлахад НИТХ, НЗД нь хуулиар хүлээлгэсэн зарим чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:
  - НИТХ, НЗД, автозамын асуудал хариуцсан байгууллагаас а/. Нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах журам, б/. Нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмуудыг боловсруулж батлуулах чиг үүргээ биелүүлээгүйгээс хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6<sup>5</sup>, 27 дугаар зүйлийн 27.4<sup>6</sup> заалтууд хэрэгжээгүй, журмыг 2022 оны байдлаар боловсруулаагүй байна. Харин 2022 оны 03 сард НЗХГ-т “Мэдээллийн сангийн хэлтэс” нэгжийг бий болгож журам боловсруулах судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1<sup>7</sup>-д заасан нийслэлийн автозамыг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөөг 2018 онд “НЗТХ” ОНӨААТҮГ боловсруулсан ч нийслэлийн удирдлагууд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор батлагдаагүй.
2. ЗХАБТХ-д заасан замын хөдөлгөөнийг зохицуулах чиглэлээр:
  - НИТХ, НЗД, замын хөдөлгөөнийг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагаас зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө батлуулах чиг үүргээ биелүүлээгүйгээс хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2<sup>8</sup> заалт хэрэгжээгүй байна.
3. ОАТТХ-иар 2017 он хүртэл хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашиныг онцгой албан татвараас чөлөөлөх, онцгой албан татварыг 50%-иар хөнгөлөх зохицуулалт үйлчилснээр 10-аас дээш жилийн насжилттай хуучирсан тээврийн хэрэгсэл ихээр орж ирсэн нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж, агаарын бохирдол болон замын хөдөлгөөний ачаалал нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор дээрх заалтыг хүчингүй болгожээ.

<sup>5</sup> 12.1.6.нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хэрэгжүүлэх;

<sup>6</sup> 27.4....., нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.

<sup>7</sup> 12.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

<sup>8</sup> 9.2.2.зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө батлах;

4. ЗТХ-иар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн тохиолдолд мөнгөн торгуулийн арга хэмжээ авах зохицуулалтыг тусгасан.
5. ГТХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>9</sup>, МУИГӨТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.4<sup>10</sup>-д заасныг зөрчиж ТАХ-ний эхлэх хугацааг газар чөлөөлөлттэй зэрэгцүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөдгөөс хэрэгжилт, үе шатны ажил удаашрах үр дагаварыг үүсгэж байна.

#### **Нийслэлээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:**

Замын хөдөлгөөний ачааллыг бууруулж, зохион байгуулалтыг сайжруулахтай холбоотойгоор НИТХ, НЗД холбогдох газруудаас хууль эрх зүй, төсөл хөтөлбөрийн хүрээнд шат дараалсан арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:


| <b>Хүснэгт 2. Эрх зүйн зохицуулалт, арга хэмжээ</b> |             |                     |                        |
|-----------------------------------------------------|-------------|---------------------|------------------------|
| №                                                   | Нэр         | Тухайлсан харилцааг | Байнгын үйлчилж байгаа |
|                                                     |             | зохицуулсан         | Тоо                    |
| 1                                                   | Сайд        | -                   | 1                      |
| 2                                                   | НИТХ        | 11                  | 2                      |
| 3                                                   | НЗД         | 95                  | 15                     |
|                                                     | <b>Нийт</b> | <b>106</b>          | <b>18</b>              |

- МУЗГ-ын 2018 оны 239 дугаар тогтоолоор МУЗХД-ийг шинэчлэн баталсан. Тус дүрмээр “тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дугаар тушаалаар “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-аар “замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, бүртгэл, судалгаа хийх” харилцааг зохицуулж байна.
- Дээрх журмыг хэрэгжүүлэх хүрээнд нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор НИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 33/35 дугаар тогтоолоор замын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх цагийн хуваарь, автомашины тоо, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлагыг тогтоож, төлбөрийн хувь хэмжээ, ачиж журамлах үйл ажиллагаа явуулах байршлыг баталсан.
- НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолоор “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ыг баталж, 2011 оны 7/66 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.
- НИТХ-аас 2012 оны 2/08 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хэт ачааллаас урьдчилан сэргийлэх, иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчуулах боломжийг нэмэгдүүлэх” зарим арга хэмжээг баталжээ. Тогтоолын дагуу НЗД “Улаанбаатар хотын автозамын хэт ачааллаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авах тухай” А/532 дугаар захирамжаар 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ний өдрийг хүртэл тогтоосон хязгаарлалтын бүсэд тээврийн хэрэгслийг ажлын өдрүүдэд 08:00-20:00 цагийн хороонд улсын дугаарын ялгавартайгаар замын хөдөлгөөнд оролцох талаар тусгасан. Анх батлагдсанаас хойш 4 удаа хязгаарлалтын бүс, цагийн хуваарийг шинэчилж, өнөөдрийн байдлаар НЗД-ын 2020 оны А/1037 дугаар захирамжаар Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн улсын дугаараар ялгаж замын хөдөлгөөнд оролцуулах цаг, нутаг дэвсгэрийн бүсчлэл”-ийг тус тус баталж ТХХХТЖ-д дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

<sup>9</sup> Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.

<sup>10</sup> Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргахаас нэгээс доошгүй жилийн өмнө газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар өмчлөгчтэй энэ тухай урьдчилан тохиролцсон байна.

## Дүрслэл 2. НЗД-аас гаргасан захирамж, шийдвэр



- НЗД-ын 2017 оны А/17 дугаар “Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамж<sup>11</sup>-аар шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл буюу 3 жилийн хугацаанд зогсоох шийдвэр гаргасан ч Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18<sup>12</sup> дах хэсэгт заасныг зөрчсөн гэж үзжээ.

Дээрх замын хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн баримт бичгийн хүрээн дэх арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Тухайлбал:

НИТХ-ын 2015 оны 33/35 дугаар тогтоолын хүрээнд 2019-2021 онд замын хөдөлгөөнд саад учруулсан 129,027 тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн байна.

### Хүснэгт 3. Зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгсэл

| №    | Дүүрэг нэр | ААНБ-ын тоо | Машины тоо | Хамрах огноо |        |        |         |
|------|------------|-------------|------------|--------------|--------|--------|---------|
|      |            |             |            | 2019         | 2020   | 2021   | Нийт    |
| 1    | БГД        | 4           | 7          | 6,464        | 5,984  | 7,653  | 20,101  |
| 2    | БЗД        | 4           | 23         | 6,596        | 8,188  | 18,751 | 33,535  |
| 3    | СБД        | 2           | 24         | 11,029       | 14,101 | 13,639 | 38,769  |
| 4    | СХД        | 1           | 9          | 349          | 189    | 378    | 916     |
| 5    | ХУД        | 2           | 12         | 1,382        | 1,885  | 8,921  | 12,188  |
| 6    | ЧД         | 1           | 24         | 1,017        | 2,797  | 19,704 | 23,518  |
| Нийт |            | 14          | 99         | 26,837       | 33,144 | 69,046 | 129,027 |

- Нийт ачилтын 41.8%-ийг СБД эзэлж байгаа нь нэг талаас тээврийн хэрэгслийн тоо жил бүр өссөн, хотын төвийн хэт төвлөрөл, нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоолын хүрэлцээгүй байдалтай холбоотой байна.
- 2019-2021 онд дунджаар 70 байршилд /1747 автомашины багтаамжтай зогсоол/ төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэх иргэн, ААНБ-тай НАЗХГ гэрээ байгуулан ажилласан хэдий ч зогсоолын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.
- Зогсоолын хүрэлцээг сайжруулах зорилгоор НЗД-ын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан “УБ хотын авто зогсоолын хүртээмжийг сайжруулах, гадаад орны авто зогсоолын менежментийн тэргүүн туршлагыг нутагшуулах талаар судалж танилцуулах ажил”-ын хүрээнд УБ хотын төвийн 6 дүүрэгт нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ үзүүлэх эрэлт, хэрэгцээг тооцож танилцуулан /26 байршилд 3,410 авто машины багтаамжтай ил зогсоол, 69 байршилд 3,422 авто машины багтаамжтай газар доорх зогсоол, 17 байршилд 4,920 авто машины багтаамжтай давхар зогсоол гэсэн 3 төрөлд хувааж нийт 26 га талбайд ойролцоогоор 11,752 авто машины зогсоол байгуулах/ судалгаа шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллээр хангасан ч үр дүн хангалтгүй байна.
- Нийтийн тээврийн хэрэгслийг 1 дүгээр эгнээгээр зорчуулах шийдвэрийн /НИТХ-аас 2012 онд баталсан “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хэт ачааллаас урьдчилан сэргийлэх, иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчуулах боломжийг нэмэгдүүлэх” зарим арга хэмжээний тухай 2/08 дугаар тогтоол/ хэрэгжилтийг судлахад сүүлийн 3 жилийн байдлаар дунджаар 289,539 тээврийн хэрэгсэл 1-р эгнээгээр зорчин зөрчил гаргасан байна. Зөрчил гарган хөдөлгөөн оролцсон тээврийн хэрэгслийн тоо 2022 онд өмнөх онуудаас 7.7%-иар өссөн байна.

<sup>11</sup> ...эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай, албан томилолтоор нийслэлд зургаан сараас дээш хугацаагаар ажиллах төрийн албан хаагч, түүний гэр бүл, Улаанбаатар хотод орон сууц худалдан авснаас бусад тохиолдолд хөдөө орон нутгаас нийслэлд ирэх;

<sup>12</sup> улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

- Даваагаас Баасан гариг хүртэл улсын дугаарын сүүлийн оронгоор төгссөн тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцох шийдвэрийн хэрэгжилттэй танилцахад өдөрт дунджаар 6000-7000 тээврийн хэрэгсэл хязгаарлагдсан өдрөө хөдөлгөөнд оролцсон байна.

Тээврийн хэрэгсэл дугаарын хязгаарлалт зөрчсөн болон 1 дүгээр эгнээгээр хөдөлгөөнд оролцсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин дутмагаас ТЦА-ны алба хаагчид Зөрчлийн тухай хуулийн 14.7<sup>13</sup> дугаар зүйлийн 50<sup>14</sup>-д заасан замын тэмдэг, тэмдэглэлийг зөрчсөн заалтын дагуу торгуулийн арга хэмжээ авч байгаа боловч торгууль төлөх хугацааг тодорхой заагаагүй байна.

Төрөөс замын хөдөлгөөнийг зохицуулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг цаг тухай бүр хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч хүн амын болон тээврийн хэрэгслийн тоо өсөн нэмэгдэхийн зэрэгцээ нийтийн тээврийн үйлчилгээ, хүртээмжгүй байдал, хууль эрх зүйн орчин нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

**Дүгнэлт:** Замын хөдөлгөөнийг зохицуулахтай холбоотой эрх зүйн баримт бичгийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч хотын төвийн төвлөрөл, авто тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаагаас шалтгаалж үр дүн нь хангалтгүй байна.

### **1.1.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын уялдаа хангагдаж байна уу?**

Замын хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжуудад батлагдсанаас хойш 3-20 удаа нэмэлт өөрчлөлт хийжээ. Тухайлбал:

- АЗТХ 2017 онд шинэчлэгдэн батлагдаж 3 удаа нэмэлт, өөрчлөлт хийгджээ.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 онд шинэчлэгдэн батлагдаж 7 удаа нэмэлт өөрчлөлт хийгджээ.
- Авто тээврийн тухай хууль 1999 онд анх батлагдсанаас хойш нийтдээ 22 удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэн байна.
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль нь 1994 онд анх батлагдан мөрдөгдөж байгаад 2021 онд шинэчлэн найруулж Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль холбогдох эрх зүйн баримт бичгүүдтэй уялдан хэрэгжиж байна.

Аудитын явцад хууль тогтоомжийн хэрэгжилт нь бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгаа талаар холбогдох байгууллага, ажилтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулан мөн үүсдэг хүндрэл бэрхшээлийн талаар НЗХГ, ХБХГ, ННТГ, ЗХУТ зэрэг байгууллагуудаас судалгаа авахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

- Авто замыг барих, засварлах, арчлахад инженерийн шугам сүлжээ гэмтэх эрсдэл үүсдэг учир усан хангамж, дулаан, цахилгааны асуудал хариуцсан байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай болдог. Гэтэл дээрх асуудлыг хариуцсан газрууд нь нэгдсэн мэдээлэлгүй байдгаас графикт хугацааны засвар арчлалтыг хийхдээ шинээр хийгдсэн автозамыг хуулах, сэтлэх зэргээр гэмтээж чанарыг нь алдагдуулж байна. Энэ нь иргэдийн аюулгүй амьдрах эрх зөрчигдөх, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын чанар алдагдах, эвдрэх, гэмтэх, устах, замын хөдөлгөөний ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай байна.
- ЗГ-ын 2011 оны 153 дугаартай тогтоолоор баталсан “Жишиг норматив”-т зааснаар замын хөдөлгөөн зохицуулах, хяналт тавих чиг үүрэгтэй тээврийн цагдаагийн 1 алба хаагчид 350 тээврийн хэрэгсэл оногдох нормативтай байдаг. Гэтэл бодит байдалд дунджаар 1400 орчим ногдож ачаалал нь 4 дахин их байна. Үүнээс шалтгаалж алба хаагч ажил үүргээ гүйцэтгэхэд ачаалал их, цаг агаарын аюултай нөхцөл байдалд замын голд зохицуулалт хийхэд үзэгдэх орчин хязгаарлагдмал, бүрэнхий гэрэлгүй

<sup>13</sup> Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

<sup>14</sup> Энэ зүйлийн 48, 49 дэх хэсэгт зааснаас бусад байдлаар замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

үед зохицуулагч зам тээврийн осолд өртөх, алба хаагчид эрүүл мэндээрээ хохирох эрсдэл үүсэж байна.

- Замын хөдөлгөөн, автозам, авто тээврийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 281 стандарт, норм нормативд салбаруудын онцлог байдлыг тусгасан байна.

**Дүгнэлт:** Салбарын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартууд нь уялдаатай байна. Харин зарим салбар хоорондын үйл ажиллагаа уядаагүй байна.

## 1.2. Бодлогын баримт бичиг хоорондын уялдаа хангагдаж байна уу?

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдох давхардсан тоогоор 38 зорилт, 168 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна. Тухайлбал:

- “Алсын хараа-2050” урт хугацааны баримт бичигт 6 зорилт 32 арга хэмжээ /дэд бүтцийн чиглэлээр 5 зорилт 8 арга хэмжээ, авто замын чиглэлээр 1 зорилт 24 арга хэмжээ/;
- “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлага” урт хугацааны баримт бичигт 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ;
- МУЗГ-ын 2013-2016, 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хүрээнд 3 зорилт 14 арга хэмжээ;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд авто зам чиглэлээр 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ;
- НЗД-ын 2013-2016, 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 14 зорилт 74 арга хэмжээ, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд 7 зорилт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.1<sup>15</sup>-д заасны дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтөд нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмуудыг баримтлахаар тусгасан.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан нийслэлийн замын хөдөлгөөнтэй холбоотой, зорилт арга хэмжээ нь харилцан уялдаатай байгаа эсэх талаар судлахад дараах байдалтай байна.

“Алсын хараа-2050” тусгагдсан дэд бүтэц, авто замын чиглэлийн зорилт, арга хэмжээ болон “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан зорилт, арга хэмжээний харилцан уялдаа хангагдсан байна. Тухайлбал:

“Олон улсын стандартад нийцсэн холимог тээврийн сүлжээ бүрдсэн байх”, “Үндэсний тээвэр, логикийн тогтолцоог хөгжүүлсэн байна” зэрэг арга хэмжээнүүд дээрх чиг хандлагын баримт бичгийн “Замын хөдөлгөөний менежменттэй уялдуулан оновчтой нэгдсэн цогц хотын гудамж замын сүлжээг бий болгох” зорилтод туссан “Ачаа тээвэр, логикийн төв байгуулах” заалттай нийцсэн байна.

“Хотын хэвтээ, босоо, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, дагуул, хаяа хотын авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх”, “Хот, тосгоныг холбосон хурдны зам барьж байгуулах” зэрэг арга хэмжээ нь замын хөдөлгөөний менежменттэй уялдуулан оновчтой нэгдсэн цогц хотын гудамж замын сүлжээг бий болгох” зорилтод туссан “2020 оны хэмжээнд гол болон туслах замын уртыг 3 дахин нэмэгдүүлэх, 2030 онд хатуу хучилттай замыг 3000км-т хүргэх 60 км урттай хурдны зам барих” заалттай нийцсэн байна.

МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд 2012-2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан УБ хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, дагуул

<sup>15</sup> 5.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

хотыг хөгжүүлэх, орон зайн оновчтой төлөвлөлт, хотын төвлөрөлийг задалж, дэд бүтэц хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, авто замын сүлжээ, тээвэр логикийн тогтолцоог хөгжүүлэх, олон төрөлт, нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050”, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-үүдтэй уялдсан байна. Тухайлбал:

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан “Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлэх”, “Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлэх” арга хэмжээнүүд нь “Алсын хараа-2050”, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийн “Авто зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгох”, “Хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох”, “Явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах, өргөтгөх, нүхэн, гүүрэн гарцыг нэмэгдүүлж хяналтын системийг бий болгоно”, заалттай нийцсэн байна. Тухайлбал:

НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд 2012-2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан хот төлөвлөлт, газрын харилцаа, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого, дагуул хот суурингууд, алслагдсан дүүргүүдийг хөгжүүлэх, дэд бүтэц, бүтээн байгуулалт, авто зам тээврийн сүлжээг хөгжүүлэх, нийтийн тээврийг шинэ шатанд гаргах, тээвэр логистик, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт арга хэмжээ нь “Алсын хараа-2050”, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдсан байна.

НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан “Улаанбаатар хотод ачаа тээврийн логикийн төвийн шинэ гарцуудыг /терминал/ барих” арга хэмжээнүүд нь “Алсын хараа-2050”, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан “Үндэсний тээвэр, логикийн тогтолцоог хөгжүүлсэн байна”, “Ачаа тээвэр, логикийн төв байгуулах” заалттай нийцсэн байна.

о “Явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээ нь МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх”-ээр тусгагдаж “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг” болон “Алсын хараа-2050”-д “Явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах, өргөтгөх, нүхэн, гүүрэн гарцыг нэмэгдүүлж хяналтын системийг бий болгох” заалттай нийцсэн байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийслэлийн авто замын зохицуулалттай холбоотой тусгагдсан холбогдох чиглэл, зорилго, зорилт, арга хэмжээнүүд харилцан уялдаатай байна.

**Дүгнэлт:** Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлийн зорилт арга хэмжээ харилцан уялдаатай тусгагдсан байна.

### **1.3. Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт хангагдсан уу?**

**Улс:** Урт дунд хугацааны бодлогын баримт бичигт нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдсон 17 зорилт, 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 19 арга хэмжээ буюу 24% нь хэрэгжих хугацаа болоогүй, 45 буюу 56.9% нь арга хэмжээ хэрэгжиж дуусах хугацаа болоогүй арга хэмжээ байна. Энэ нь урт хугацааны бодлогын баримт бичигт хэрэгжүүлэх хугацааг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасантай холбоотой байна.

**Нийслэл:** Нийслэлийн дунд хугацааны баримт бичгүүдэд нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдох нийт 14 зорилтын хүрээнд давхардсан тоогоор 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнээс 29 буюу 39.1% нь бүрэн хэрэгжсэн байна. 47.2% буюу 35 арга хэмжээ хэрэгжилт дутуу, 13.5% буюу 10 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

### 1.3.1. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээ нь зохих түвшинд хүрсэн үү? /хөгжлийн бодлогын баримт бичиг, ЗГ-ын мөрийн хөтөлбөр, холбогдох урт болон дунд хугацааны баримт бичгүүд/

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдох давхардсан тоогоор 17 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал:

#### Дүрслэл 3. МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичиг

|                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Алсын хараа-2050                                                                                                 | <ul style="list-style-type: none"> <li>Хотын хэвтээ, босоо, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, дагуул, хаяа хотын авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.</li> <li>"Агаарын дүүжин замын тээвэр"-ийг нэвтрүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг барьж байгуулна.</li> <li>Явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах, өргөтгөх, нүхэн, гүүрэн гарцыг нэмэгдүүлж хяналтын системийг бий болгоно</li> <li>Олон улсын стандартад нийцсэн холимог тээврийн сүлжээ бүрдүүлэх</li> <li>Богдхан уулыг тойрсон зорчигч тээврийн сүлжээг байгуулна</li> </ul>          |
| Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх чиг хандлага | <ul style="list-style-type: none"> <li>Хөдөлгөөн зохицуулалтын менежментийг боловсронгуй болгож тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалтын бүсүүд тогтоох</li> <li>Нийтийн тээвэрт багтаамж ихтэй нийтийн тээврийн төрлийг нэвтрүүлэх</li> <li>Тусгай замын автобусны /BRT/ зам барьж байгуулна.</li> <li>Метро /LRT/-ны шугамыг барьж байгуулах ажлыг эхлүүлэхийн өмнө эдийн засгийн үр ашиг хэрэгжүүлэх бодит боломж, түүнээс үүсэх сөрөг үр дагавар зэргийг олон талаас нь үндэсний мэргэжилтнүүдийг оролцуулан нарийвчлан судлаж тооцсоны үндсэн дээр эцсийн шийдвэрийг гаргах</li> </ul> |

Дээрх төлөвлөгөөнүүдэд зам тээврийн салбарын тухайд ялангуяа замын хөдөлгөөний ачааллыг бууруулахын тулд хотын бүтцийг олон төвтэй болгож хотын төв болон дэд төвийг баруунаас зүүн тийш чиглэсэн 6 коридор, хойноос урагш чиглэсэн 9 коридор, 4 тойрог замаар холбох төлөвлөлт хийсэн байна. Түүнчлэн УБ хотын хүн амын нягтралыг сааруулах зорилгоор дагуул хотуудыг хөгжүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар хотыг өргөн хүрээний замын сүлжээтэй болгон Богдхан төмөр зам барих, дагуул хот, сумдыг холбох авто замын сүлжээ барих, 4 логистикийн төв байгуулахаар тусгасан.

Төлөвлөсөн зорилт арга хэмжээнээс 6 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 18 арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй, 9 арга хэмжээ хэрэгжээгүй, 1 арга хэмжээ хэрэгжилт дутуу, хэрэгжиж дуусах хугацаа болоогүй 44 арга хэмжээ байна. Үүнд:

#### Хүснэгт 4. Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалтын талаар тусгагдсан арга хэмжээ

| № | Бодлогын баримт бичиг                                                                                                          | Зорилт | Баталсан арга хэмжээ /тоо/ | Хэрэгжих хугацаа /он/ | Хэрэгжилт                       |           |             |                 |                                  |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|----------------------------|-----------------------|---------------------------------|-----------|-------------|-----------------|----------------------------------|
|   |                                                                                                                                |        |                            |                       | Хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй | Хэрэгжсэн | Хэрэгжээгүй | Хэрэгжилт дутуу | Хэрэгжиж дуусах хугацаа болоогүй |
| 1 | Алсын хараа-2050                                                                                                               | 6      | 32                         | 2050                  | 11                              | -         | 1           | -               | 20                               |
| 2 | УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг | 3      | 18                         | 2020-2030             | 2                               | -         | 3           | 1               | 12                               |

|   |                                                             |           |           |           |           |          |          |          |           |
|---|-------------------------------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|----------|----------|----------|-----------|
| 3 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл | 5         | 11        | 2021-2025 | 5         | -        | -        | -        | 6         |
| 4 | Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд     | 1         | 4         | 2013-2016 | -         | 1        | 3        | -        | -         |
|   |                                                             | 1         | 7         | 2016-2020 | -         | 5        | 2        | 1        | -         |
|   |                                                             | 1         | 6         | 2020-2024 | -         | -        | -        | -        | 6         |
|   | <b>Нийт</b>                                                 | <b>17</b> | <b>78</b> |           | <b>18</b> | <b>6</b> | <b>9</b> | <b>1</b> | <b>44</b> |

### **Хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй зорилт арга хэмжээний талаар:**

Дээрх баримт бичгүүдэд туссан 18 арга хэмжээний хэрэгжих эхлэх хугацаа болоогүй байна. Үүнд:

- “Алсын хараа-2050”-д тусгагдсан дэд бүтэц дагуул хот, хөгжлийн ирээдүйтэй сууриныг холбох тээвэр, логистикийн чиглэлийн 5 арга хэмжээ, авто зам инженер шугам сүлжээ, дагуул хаяа хотын замын сүлжээг барьж байгуулах чиглэлийн 6 арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байна.
- УБ хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдсан дагуул хот болон авто тээврийн талаар баримтлах бодлого чиглэлтэй холбогдох *“Төлөвлөж буй хотын төв, дэд төвүүдийг холбосон хотын чанартай тойрог зам хэвтээ болон босоо чиглэлд 5-8 параллель хотын чанартай гол замуудыг барих”, “Тээврийн сүлжээний төлөвлөлтийг боловсронгуй болгож үйлчилгээнд орчин үеийн техник технологийн ололтыг нэвтрүүлэх”* 2 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй байна.
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан дэд бүтэц Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулах, дагуул хотуудад дэвшилтэд технологи бүхий үйлдвэр, технологийг барьж байгуулах, олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлэх, хотын шинэ төв, дэд төвийг барьж байгуулах чиглэлийн 5 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй, 2021-2025 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байна.

### **Хэрэгжиж дууссан зорилт арга хэмжээний талаар:**

МУ-ын ЗГ-ын 2012-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийт 6 арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын байдлаар хэрэгжиж дууссан байна. Үүнд:

- МУ-ын ЗГ-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах” арга хэмжээний хүрээнд улсын төсөв, гадаадын зээл тусламж, нийслэлийн төсвийн 104,437.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83.63 км авто зам болон 163 у/м гүүрийг шинээр барьж ашиглалтад оруулснаар авто замыг шинэчилж, замын чанар сайжирсан үр дүн гарсан байна.
- 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дараах 5 арга хэмжээ хэрэгжсэн байна. Үүнд:
  - “Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хуулийг УИХ-аас 2021.07.07-ны өдөр баталсан. Хуульд нийслэл хот нь авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой тусгаснаар замын түгжрэлийг үе шаттай бууруулах, тухайн асуудлыг хариуцах нэгж, чиг үүрэг, цаашид хэрэгжүүлэх чиглэл нь тодорхой болох зэргээр үр дүн гарч эхэлсэн байна.
  - “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотод 2017-2020 онд нийт 75.3 км дугуйн зам шинээр барих, засварлах ажил дууссан байна.
  - “УБ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Налайх чиглэлийн автозамыг шинээр барих” арга хэмжээний хүрээнд 3 гүүрийг барилгын ажлыг бүрэн дуусган ашиглалтад оруулсан байна. Налайх-Чойрын 20.9 км авто замыг өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг дуусгаж 2019 оны 11 сард зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн байна.
  - “Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтэрсэн хот суурин газар болон ЕБС-н сурагчдад гэр сургуулийн хооронд нийтийн тээврээр үнэгүй зорчдог болгох” арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хэмжээнд нийслэлийн төрийн өмчийн 37 сургуульд 46, төрийн бус өмчийн 58 сургуулийн 134, нийт 180 “Хүүхдийн автобус” үйлчилсэн байна.

Дээрх арга хэмжээнүүд хэрэгжсэнээр нийслэлээс авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг тодорхой болох, томоохон хэмжээний гүүрэн байгууламж, автозамууд ашиглалтад орсноор автозамын сүлжээ сайжрах, хөдөлгөөний эрчим нэмэгдэх, ачаалал буурах ач холбогдолтой байна.

### **Хэрэгжиж дүүсах хугацаа болоогүй зорилт арга хэмжээний талаар:**

“Алсын хараа-2050”-д тусгагдсан 20, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан 12, “МУ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэл”, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 12, нийт 44 арга хэмжээ хэрэгжилтийн явцад байна. Үүнээс урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан 33 зорилт, арга хэмжээ нь 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ байна. Үүнд:

- Хүн амын өсөлт, хотын төвлөрөл, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, дагуул хот хөгжүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд тусгагдсан их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх, хотуудын зэрэглэлийг тогтоох, Богд уулын урдуур хот тойруулан шинээр байгуулан ачаа эргэлтийг хотоос гаргах хот доторх төмөр замыг нийтийг тээвэрт ашиглах зэрэг ажлууд;
- Авто зам, шинээр зам барьж байгуулах, засварлан шинэчлэх, өргөтгөх, явган хүний болон унадаг дугуйн зам, нүхэн гүүрэн гарцуудыг барьж байгуулах, авто зогсоолын менежментийг боловсронгуй болгох зорилт, арга хэмжээний хүрээнд тусгагдсан гол болон туслах замын уртыг 3 дахин нэмэгдүүлэх, зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгох, авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, төмөр зам дээгүүр явган зорчигчийн 5 гүүрэн гарц барих зэрэг ажлууд;
- Нийтийн тээврийн олон төрөлт үйлчилгээг нэвтрүүлэх, нийтийн тээврийн үйл ажиллагааг сайжруулах, нийтийн тээврийн төрлийг нэмэгдүүлж, уялдааг сайжруулах зорилт, арга хэмжээний хүрээнд тусгагдсан хотын дэд төвүүдийг түшиглэсэн түгээлтийн төвүүдийг байгуулж, тээвэрлэлтийг хотын захын гол замуудаар хүнд даацын том оврын тээврээр хийх нөхцөлийг бүрдүүлэх, сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлэх ажлууд.

### **Хэрэгжээгүй зорилт арга хэмжээний талаар:**

“Алсын хараа-2050”-д тусгагдсан 1, “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т 3, МУ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 5, нийт 9 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

**1.** Алсын хараа-2050-д тусгагдсан “Агаарын дүүжин замын тээвэр”-ийг нэвтрүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг барьж байгуулах арга хэмжээ:

- Нийслэлийн тээврийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, автозамын түгжрэлийн бууруулж, агаарын бохирдлыг багасгахад чиглэсэн Баянхошуу-Ханын материал-Гэмтлийн эмнэлэг чиглэлийн дүүжин тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гэрээг НЗДТГ болон БНФУ-ын “Пома болон Эжис” компаниудтай 2020 оны 3 дугаар сард байгуулж, 2020.05.12-ны өдөр УИХ соёрхон баталсан.
- Төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийг адил төстэй нийтийн тээврийн хэрэгсэлтэй харьцуулж, цаашид авах арга хэмжээний талаар шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.
- Ажлын хэсгээс дүүжин тээврээр зорчих зорчигч урсгалыг тооцох, илүү эдийн засгийн үр өгөөж сайтай хотын түгжрэлийг бууруулах талаар судалгаа гаргах, төслийн гэрээнд заагдсан чиглэлийг өөрчлөх, ТЭЗҮ боловсруулах зардлыг төслийн санхүүжилтээс гаргах зэрэг шийдвэрийг гаргасан байна.
- Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, УБ хотын түгжрэлийг бууруулах, автозам, зорчигчийн нягтрал, ашиг алдагдалын тооцоог нарийвчлан гаргах

зорилгоор ТЭЗҮ боловсруулах зардлыг төслийн үндсэн эх үүсвэрээс санхүүжүүлэх тухай нэмэлт өөрчлөлтийг хэлэлцээрт оруулах талаар БНФУ-ын талтай хэлэлцэж дүнг ЗГ-ын хуралдаанд танилцуулах шийдвэр гаргасан.

- НИТХТ-ийн 2020.07.31-ний өдрийн 126 дугаар тогтоолоор “Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ байгуулсан ч 2021.12.20-ний өдрийн 191 дугаар тогтоолоор татан буулгасан байна.
- “Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ нь 2020 онд 65.0, 2021 онд нийт 406,3, нийт 471.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.
- Дээрх арга хэмжээ нь Алсын хараа-2050 баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байна.

2. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх чиглэл”-д тусгагдсан дараах 3 арга хэмжээ хэрэгжээгүй. Үүнд:

- “Метроны шугамыг барьж байгуулах ажил”-ыг эхлүүлэхийн өмнө эдийн засгийн үр ашиг хэрэгжүүлэх бодит боломж, түүнээс үүсэх сөрөг үр дагавар зэргийг олон талаас нь үндэсний мэргэжилтнүүдийг оролцуулан нарийвчлан судалж тооцсоны үндсэн дээр эцсийн шийдвэрийг гаргах арга хэмжээний хүрээнд дараах ажлууд хийгдсэн ч зогссон байна.
  - ННТГ-аас метроны техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах ажлыг Жайка Олон улсын байгууллагын төслийн багаар гүйцэтгүүлсэн байна.
  - НЗД-ын 2013.05.30-ны өдрийн А/550 захирамжаар УБ хотод метро барих бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн байгуулж, 2013.06.12-нд шугамыг тэмдэгжүүлэх ёслолын арга хэмжээ зохион байгуулжээ.
  - 2013.08.26-ны өдөр Улаанбаатар Метро байгуулах зөвлөл хуралдаж төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах талаар хэлэлцсэн байна.
  - 2013.09.06-ны өдөр Олон улсын Clyde & со Хуулийн фирм Монголын талтай Метроны хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх талаар хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлж, уулзалт зохион байгуулсан зэрэг ажлууд хийгдсэн ч одоог хүртэл хэрэгжээгүй байна.
- “Тусгай замын автобусны /BRT/ зам барьж байгуулна” /мөн МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан/ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:
  - Төслийг МУЗГ, АХБ-тай хамтран нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобусны тээврийг нэвтрүүлэн нийтийн тээврийн салбарт парк шинэчлэлт, авто замын шинэчлэлт хийх, зам тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх замаар түгжрэлийг бууруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
  - Төслийн холбогдох тооцоо судалгааг 2009-2012 онд АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд хийж зээлийн хэлэлцээрийг 2012 онд хийж, санхүүжилт хийх боломжтой болсон ч 3 жилийн дараа буюу 2015 онд УИХ-аас дээрх хэлэлцээрийг соёрхон баталсан. УИХ-аас хэлэлцээрийг батлахад хугацаа алдсан, Метро төслийг хэрэгжүүлэх судалгааны ажилтай давхардсан зэрэг шалтгаанаар техникийн туслалцааны хүрээнд тооцоо судалгааг дахин хийх шаардлагатай болсон ч хийгдээгүй байна.
  - НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр дахин баталж 2017 онд тусгай замын автобус /BRT/ төслийн гэрээг НЗДТГ, “Азийн хөгжлийн банк”-тай байгуулж, зээлийн хэлэлцээр болон буцалтгүй тусламжаар нийт 50.8 сая ам доллар олгохыг зөвшөөрчээ.
  - 2017 онд Төслийн нэгжийг байгуулж, Тусгай замын автобусны сүлжээний дэд бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах, 1 дүгээр коридорын барилгын ажлын хяналтыг хийж гүйцэтгэх олон улсын зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зарласан байна.
  - Зөвлөхийн гэрээний төслийг АХБ-нд хүргүүлсэн ч шалгарсан байгууллага нь бүрэн шаардлага хангасан материал ирүүлээгүй үндэслэлээр цуцлагджээ.
  - Нийслэлийн Засаг дарга 2019 онд өөрчлөгдөж, тухайн жилдээ төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгжийг дахин байгуулсан ч Азийн хөгжлийн банкнаас 2020 онд зээлийн ашиглалтын хугацааг өмнө 3 удаа сунгасан тул дахин сунгах боломжгүй болсныг зарласнаар төсөл санхүүжилтгүй болж хаагдсан байна.

- Төслийг хэрэгжүүлснээр нийтийн тээврийн салбарт парк шинэчлэлт авто замын шинэчлэлт хийх, зам тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх замаар түгжрэлийг бууруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн
  - Хотын өнгө үзэмжийг шинэчилж шууд нөлөөллийг үзүүлэх, иргэдийн авто машины хэрэглээг бууруулж нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах, замын хөдөлгөөний хугацаа хурдсах,
  - Дээрх арга хэмжээ нь Алсын хараа-2050 баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байна.
- “Ачаа тээвэр, логистикийн төв байгуулах” /мөн НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан/ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:
- Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах чиглэлээр судалгаа хийж, зураглал гарган, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар баталсан.
  - Нийслэлийн зүүн хэсэгт нэгдсэн логистик төв барих 130 га газрыг 05 дугаар сард нийслэлийн мэргэжлийн байгууллагуудтай үзэж танилцсан.
  - НИТХ-ын 2018 оны 28 дугаар тогтоолоор Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ-ын эрх, үүрэг, хариуцлагыг “Олон улсын худалдаа, логистикийн төв” хаалттай хувьцаат компанид бүрэн шилжүүлсэн. Тус газраас Хангарди терминалын ТЭЗҮ хийгдсэний үндсэн дээр цаашид үйл ажиллагааг хэрхэн өрнүүлэх талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах боловч терминалын ТЭЗҮ хийлгэх төсөв батлагдаагүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.
  - Дээрх арга хэмжээ нь Алсын хараа-2050 баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Баримт бичгүүдэд тусгагдсан метро, тусгай замын автобус /BRT/, агаарын дүүжин тээвэр зэрэг арга хэмжээнүүд хэрэгжсэн бол УБ хотын нийтийн тээврийн үйл ажиллагаа сайжирч автозамын ачаалал буурах, цаг хугацаа хэмнэж шуурхай, тав тухтай зорчих боломж бүрдэх зэргээр эдийн засаг, эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх боломж алдагдсан байна.

**3. МУ-ын ЗГ-ын 2013-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дараах 4 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:**

- “Улаанбаатар хотын авто замын сүлжээг тойрог замын системд шилжүүлж, гүүрэн гарц, хоёр түвшний уулзварыг шаардлагатай газарт барьж байгуулах арга хэмжээний хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:
- БНХАУ-ын ЗГ-аас МУ-ын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд УБ хотод гол гудамж замуудын уулзвар, төмөр зам дээгүүр шинэ гарцуудыг барьж замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, түгжрэлийг бууруулах зорилгоор УИХ-аас баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр болон УБ хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 6 гүүрэн гарц, олон түвшний огтлолцлуудыг барих, баруун, зүүн 4 замын уулзвар дээр олон түвшний огтлолцол барих шийдвэрлэсэн.
  - Зүүн 4 замын олон түвшний огтлолцлыг барих ажлыг БНХАУ-ын Төмөр замын 15-р хорооны групп корпорац, “Заабар” ХХК-ны түншлэлтэй 2012-2014 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч уг ажлыг зогсоон “Гудамж” төслийн хүрээнд баригдах хурдын замын төлөвлөлттэй уялдуулж хийхээр шийдвэрлэсэн ч хэрэгжээгүй;
  - Баруун 4 замын олон түвшний огтлолцол барих ажлыг БНХАУ-ын “Чайна Интернэшл Рэливэй” компанитай 2012-2015 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч “Гудамж” төслийн хүрээнд баригдах хурдын замын төлөвлөлттэй уялдуулж хийхээр шийдвэрлэсэн /Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд газар метроны шугам барих ажилтай уялдуулан хийхээр хойшилсон/ уг ажлыг зогсоон.
  - Яармагийн хос гүүрийг хос болгон өргөтгөн шинэчлэх, Замын цагдаагийн газрын баруун уулзвар дээр төмөр зам дээрх гүүрэн гарц барих, Нарны зам болон Ажилчны гудамжийг холбосон төмөр зам дээр гүүрэн гарц барьж 3 гүүрийг ашиглалтад оруулсан байна
  - Толгойт Сонсголонгийн замын уулзвар, Саппорогийн аюулгүй тойрог дээр олон түвшний огтлолцлыг барих, Баянбүрдийн аюулгүй тойрог дээр олон түвшний огтлолцлыг барьж ашиглалтад оруулах ТАХ-үүд нь ЗГ-ын 2013 оны 127 дугаар тогтоолоор “Гудамж” төслийн хүрээнд шийдвэрлэхээр тусгагдаж хэрэгжээгүй байна.
  - “Шинэ Улаанбаатар” төслийн хүрээнд хот төлөвлөлтийг шинээр хийж, нэгдсэн бодлогоор инженерийн дэд бүтцийг байгуулан, иж бүрэн 17 хорооллыг байгуулах,

Нийслэлийн алслагдсан дүүрэг, дагуул хотын хөгжлийг бодлогоор дэмжиж, иргэдийн суурьших бүсийг тэлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан тус ажлын хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн дагуу инженерийн шугам сүлжээ, авто зам барих ажлыг эхлүүлж, нийт 8 байршилд 44 км гудамж зам гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах байгууламжийн зураг төсөл боловсруулагдсан. Мөн 2 дүүрэг /СБД, БЗД/-т хэсэгчилсэн 2 талдаа 2.25м өргөнтэй явган хүний зам гэрэлтүүлэг бүхий 12 км зам барих ажлыг эхлүүлсэн. Гэвч тус арга хэмжээний хүрээнд хийгдэх иж бүрэн 17 хороолол байгуулах, алслагдсан дүүрэг, дагуул хотын хөгжлийг бодлогоор дэмжиж, иргэдийн суурьших бүсийг тэлэх зорилтыг хэрэгжүүлээгүй байна.

- “Улаанбаатар хотын хатуу хучилттай авто замыг бүрэн шинэчлэх” арга хэмжээний хүрээнд 457.26 у/м гүүрийг өргөтгөн шинэчилж, орон сууцны хороолол доторх 49.46 км замын засварын ажлыг хийсэн ч зорилтод түвшиндээ хүрээгүй байна.
- МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/- ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх” арга хэмжээний хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/- ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд 3 гүүрийг бүрэн ашиглалтад оруулсан /Баянзүрх,яармаг, сонсголон/ боловч тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх арга хэмжээ хэрэгжээгүй байна.

“Улаанбаатар хотын орон сууцны хороолол,нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд Их тойруугийн 1113.2 га талбайд хийсэн судалгаагаар ил зогсоол 114, дээрээ тохижилт бүхий газар доорх автомашины зогсоол 20, давхар зогсоол 3 байршилд тус тус төлөвлөж, 2018-2019 онуудад нийт 12 эмнэлгийн гадна талбайд 1167 тээврийн хэрэгслийн багтаамжтай автомашины зогсоолыг бүрэн хийж ашиглалтад оруулж, нийслэлд төлбөртэй зогсоол ажиллуулахаар 2016 онд 8, 2017 онд 26, 2018 онд 45, 2019 онд 61, 2020 онд 68 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай жил бүр гэрээ байгуулж, 2016 онтой харьцуулахад 2020 онд зогсоолын тоог 9 дахин нэмэгдүүлж, газар доорх зогсоол 1 байршилд 104 автомашины зогсоол, давхар зогсоол 1 байршилд байгуулах хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусган гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажилласан боловч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

### **Хэрэгжилт дутуу арга хэмжээ:**

“УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсан шинээр автомашин гүүрэн гарц-5, олон түвшний огтлолцол-17, явган хүний гүүрэн гарц-14 барих арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.

Төрөөс замын хөдөлгөөний талаар баримтлах нэгдсэн бодлого байхгүй, харин урт, дунд хугацааны баримт бичиг, зарим салбарын бодлогын баримт бичгийг баталсан байна. Тухайлбал:

- УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"
- ЗГ-ын 2018 оны 321 дүгээр тогтоолоор Төрөөс авто тээврийн салбарт баримтлах бодлого
- 2019 оны 70 дугаар тогтоолоор “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого” зэргийг баталсан.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт “Нийслэлийн авто зам, Нийтийн тээврийн салбар”-ыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар тусгасан ч одоогийн байдлаар батлагдаагүй байна.

- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Түгжрэлгүй гудамж-Бухимдалгүй хот”

зорилтын хүрээнд дээрх төлөвлөгөөг боловсруулах үүргийг НЗХГ, НТГ-т даалгасан.

- НЗХГ-аас хариуцан авто замын мастер төлөвлөгөөг “НЗТХ” ОНӨААТҮГ-аас боловсруулсан ч НИТХ-аар батлаагүй байна.
- НТГ-аас нийтийн тээврийн салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах судалгааны ажил хэрэгжүүлсэн ч санхүүжилтийн асуудлаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Дээрх бодлогуудад төмөр зам, авто тээврийн салбарыг эдийн засгийн өсөлтийг хангах, эрэлтэд нийцсэн, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, бүс нутагт өрсөлдөхүйц тээврийн үйлчилгээ үзүүлэгч, нийгмийн тэргүүлэгч салбар болгон хөгжүүлэхэд зэрэг асуудлыг тусгасан. Урт, дунд хугацааны баримт бичигт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой зорилт арга хэмжээг түлхүү тусгаж байна.

Иймд замын хөдөлгөөнийг зохицуулах нэгдсэн бодлогыг боловсруулж батлуулж, төрөөс цаашид баримтлах чиг хандлагыг тодорхой болгох шаардлага тулгарч байна.

**Дүгнэлт:** Урт, дунд хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан зарим арга хэмжээ хэрэгжээгүйгээс нийтийн тээврийн үйлчилгээ сайжрах, автозамын ачаалал буурах, улмаар улс орны нийгэм, эдийн засаг болон иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх боломжууд алдагдсан байна.

### 1.3.2 Нийслэлээс баримталж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ нь зохих түвшинд хүрсэн үү? / Нийслэл, дүүргийн ИТХ-аар баталсан шийдвэрүүд, ЗД-ын мөрийн хөтөлбөр, холбогдох бусад баримт бичгүүд/

Нийслэлийн дунд хугацааны баримт бичгүүдэд нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдох нийт 14 зорилтын хүрээнд давхардсан тоогоор 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

**Дүрслэл 4. НИТХ-аар баталсан шийдвэрүүд**



Төлөвлөсөн зорилт арга хэмжээнээс 29 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 10 арга хэмжээ хэрэгжээгүй, 35 арга хэмжээ дутуу хэрэгжилттэй байна.

### **Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбоотой 5 зорилт, 18 арга хэмжээ тусгагдсанаас 12 буюу 66.6%, 2016-2020 онд 5 зорилт, 29 арга хэмжээнээс 12 буюу 41.3%, 2020-2024 онд 4 зорилт, 27 арга хэмжээнээс 5 арга хэмжээ буюу 18.5% нь тус тус хэрэгжсэн байна.

**Хүснэгт 5. НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжилт**

Нийслэлээс баримталж буй бодлого

| Бодлого                        | Хамрагдах он | Зорилт                                                                      | Баталсан    |                                     | Хэрэгжилт |             |
|--------------------------------|--------------|-----------------------------------------------------------------------------|-------------|-------------------------------------|-----------|-------------|
|                                |              |                                                                             | Арга хэмжээ | Үүнээс замын хөдөлгөөнтэй холбоотой | Хэрэгжсэн | Хэрэгжээгүй |
| НЗД-н үйл ажиллагааны хөтөлбөр | 2013-2016    | Хот төлөвлөлт, газрын харилцааг ил тод болгох                               | 3           | 2                                   | 2         |             |
|                                |              | Иргэндээ ээлтэй эрүүл, аюулгүй, тохилог орчин                               | 12          | 4                                   | 3         | 1           |
|                                |              | Авто зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр                              | 10          | 10                                  | 7         | 3           |
|                                |              | Дагуул хот, сууринууд, алслагдсан дүүргүүдийг хөгжүүлэх                     | 3           | 1                                   |           | 1           |
|                                | 2016-2020    | Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр                                       | 2           | 1                                   | 1         |             |
|                                |              | Ухаалаг төлөвлөлт ил тод газрын харилцаа                                    | 8           | 2                                   |           | 1           |
|                                |              | Түгжрэлгүй гудамж-Бухимдалгүй хот                                           | 12          | 12                                  | 3         | 9           |
|                                |              | Нийтийн тээврийн шинэ шатанд гаргана                                        | 11          | 11                                  | 5         | 2           |
|                                |              | Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.                              | 5           | 3                                   | 2         | 1           |
|                                |              | Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ                                              | 9           | 1                                   | 1         |             |
|                                |              | Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого                               | 3           | 4                                   | 1         | 3           |
|                                |              | Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна. | 9           | 3                                   |           | 4           |
|                                | 2020-2024    | Улаанбаатар хотын авто замын үндсэн сүлжээг хөгжүүлнэ.                      | 18          | 18                                  | 4         | 2           |
|                                |              | Тээвэр, логистик                                                            | 6           | 2                                   |           | 1           |
|                                |              | <b>Нийт</b>                                                                 | <b>111</b>  | <b>74</b>                           | <b>29</b> | <b>10</b>   |
|                                |              |                                                                             |             |                                     |           | <b>35</b>   |

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны зорилт хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээг УБЗАА, ХБХГ, НЗХГ, НТГ, НБГ, НГЗА, ЗХУТ үйл ажиллагааныхаа төлөвлөгөө хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

Аудитад хамаарах 14 зорилт, 74 арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүргийг НЗД-ийн харьяаны 7 байгууллага хариуцан ажиллаж байна.

**Хэрэгжиж дууссан зорилт арга хэмжээний талаар:**

Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбоотой нийт 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 29 буюу 39.1% нь хэрэгжиж дууссанаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

НЗД-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хот төлөвлөлт, иргэндээ эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, авто зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжсэн байна. Тухайлбал:

- “Гэр хорооллын доторх авто замын сүлжээг сайжруулж хатуу хучилттай авто зам барих арга хэмжээ” хэрэгжиж 2012-2015 онд гэр хорооллын доторх 18 байршилд авто замын сүлжээг сайжруулж, 98.14км авто замыг өргөтгөн, шинэчилсэн байна. “Хотын алслагдсан суурьшлын цэгүүдэд үзүүлж байгаа нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ” бүрэн хэрэгжиж шинээр 6 чиглэл нээж, 11 чиглэлийг сунгаж, 34 чиглэлд өөрчлөлт оруулжээ.
- “Улаанбаатар хотод шинээр 212 км авто зам барьж, 350 км авто замыг шинэчлэх арга хэмжээ” хэрэгжиж 2012-2015 онд 41 чиглэлийн 175.77 км авто замыг 191,014.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр өргөтгөж шинэчилж, 34 чиглэлийн 83.63 км авто замыг 108,648.8 сая төсөвт өртгөөр шинээр ашиглалтанд оруулсан байна.
- “Нийтийн тээврийн автобусны бүртгэлийн GPS систем, тээвэрлэлтийн цахим төлбөрийн систем нэвтрүүлэх” арга хэмжээ хэрэгжиж нийтийн тээвэрт шинэчлэл хийх “Ухаалаг автобус” төслийг хэрэгжүүлж, нийтийн тээврийн хэрэгслүүд болон удирдлагын төвд суурилуулагдах тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, суурилуулах, системийн тоног төхөөрөмжийг турших, цахим төлбөрийн системийн эрхзүйн орчинг бий болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн, иргэд автобусаар зорчихдоо цахим картаар төлбөрөө хийж эхэлсэн байна.

НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцаа, түгжрэлгүй гудамж-бухимдалгүй хот, нийтийн тээврийг шинэ шатанд гаргах,

сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт арга хэмжээгээр тусгагдсан 29 арга хэмжээнээс 12 арга хэмжээ хэрэгжсэн байна. Тухайлбал:

- “Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох” Газар эзэмших, ашиглах үйл ажиллагааг ил тод, болгох хүрээнд газрын дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулан “Газрын биржийн цахим төв”-ийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн байна.
- “Хөшгийн хөндийн хурдны зам барьж Туулын хурдны зам барих ажлыг эхлүүлэх” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар-Хөшгийн хөндийн Олон улсын шинэ нисэх буудал чиглэлийн 32.2 км хурдны авто замын барилгын ажлыг график төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн хүлээлгэн өгч, ашиглалтад оруулсан байна.
- “Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж, иргэдийн эрэлтэд нийцсэн шинэ чиглэл бий болгох” арга хэмжээний хүрээнд их багтаамжийн 733 автобус, такси 865, туслах, буухиа 27, нийт 1521 тээврийн хэрэгслээр нөхөн хангалт, хувийн хэвшлийн хөрөнгөөр 11 автобус, улсын төсвөөр 11 цахилгаан автобусаар нийт 22 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийж, нийт 15 чиглэл шинээр нээсэн байна.
- “Эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн ухаалаг системийг боловсронгуй болгох” арга хэмжээний хүрээнд УБ хотын хэмжээнд нийт 144 уулзвар болон явган зорчигчийн гарцын гэрэл дохио, 25 цэгт байрлах зөрчил илрүүлэх төхөөрөмж, 38 цэгт байрлах телекамер 2 цэгт мэдээллийн самбар, 52 цэгт байрлах хөдөлгөөн мэдрэгч төхөөрөмж зэргүүдийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, 48 уулзварын гэрлэн дохионы горим шинээр программчилж өөрчлөлт оруулсан байна.

НЗД-ын “2020-2024” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 27 арга хэмжээнээс 2022 оны байдлаар 5 арга хэмжээ хэрэгжсэн байна. Тухайлбал:

- “Гудамж замд засвар арчлалт хийх” НЗД-ын 2021 оны А/141, А/209, А/229, А/273, А/692, А/847 дугаар захирамжийн дагуу хотын гол болон туслах 176 гудамж, 574 км замд засвар арчлалт хийхээр 20.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, Үүний дагуу нийт 574 км замд 76600 м<sup>2</sup> нөхөөс, 32 гудамжинд 300000 у/м заадас, гэр хорооллын шороон замын 120000 м<sup>2</sup> хусаж тэгшлэх, 65375 м<sup>2</sup> тэмдэглэгээ, гүүрэн гарцын 101 у/м хэв гажилтын заадас, 20 у/м гүүрийн төмөр бетон хайс засвар, 198 м ус зайлуулах шугамын ажил тус тус хийгдсэн байна.
- “Сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар еранхий боловсролын сургуулийн барилга ашиглалт, ачааллын чааллын коэффициентийг бууруулж, 1.46 хувьд хүргэх” арга хэмжээний хүрээнд 2021-2022 онд сургуулийн ачааллын коэффициентийг бууруулахаар 11 сургуулийн байрыг шинээр ашиглалтанд оруулж, НТХО-аар сургалтын зориулалтаар ашиглах 18 түрээсийн байранд 8750 хүүхдийг хамруулсан байна. Ингэснээр сургуулийн барилга ашиглалтын коэффициент 1.53-аас 1.51 болж буурсан үзүүлэлттэй болжээ.

#### **“Хэрэгжиж дуусах хугацаа болоогүй зорилт арга хэмжээний талаар:**


Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбоотой нийт 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 35 буюу 47.2% нь дутуу хэрэгжилттэй байна. Үүнээс 20 арга хэмжээ нь 2013-2020 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан ч хэрэгжилт дутуу он дамжин хэрэгжүүлсэн арга хэмжээ байна. Тухайлбал:

- Олон түвшний огтлолцлыг 6 уулзварт барьж авто замын сүлжээг хөгжүүлэх ажлыг НЗХГ-т гүйцэтгүүлэхээр даалгасан ч ЗГ-ын 2013.03.30-ны 127 дугаар тогтоолоор “Гудамж” төслийн хүрээнд шийдвэрлэхээр болсон байна.
- “Улаанбаатар хотод шинээр 212 км авто зам барьж, 350 км авто замыг шинэчлэх” арга хэмжээний хүрээнд 2012-2015 онд 41 чиглэлийн 175.77 км авто замыг өргөтгөж шинэчилж, 34 чиглэлийн 83.63 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд зорилтод түвшиндээ хүрээгүй байна.
- “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт 15 дагуул хаяа хот тосгодтой байхаар тусгагдсан. Үүнээс 11 дагуул хаяа хот тосгодын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж 4 хаяа хот тосгодод шаардлагатай хөрөнгийг

2017-2020 оны төсөвт тусгуулах тухай саналыг хэрэгжүүлэгч байгууллагаас хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй байна.

- "Гол гудамж, замуудын хөдөлгөөн нэвтрүүлэх чадварыг сайжруулж, Баруун, Зүүн 4 замын уулзварт олон түвшний огтлолцол байгуулах ажил"-ыг НЗХГ-т даалгасан байна. Хэрэгжүүлэгч байгууллагаас зүүн 4 замын уулзварт олон түвшний огтлолцол барихад шаардагдах санхүүжилтийн санал хүргүүлсэн ч төсөвт тусгагдаагүй байна.

**График 1. Дутуу хэрэгжсэн арга хэмжээ**



### **Хэрэгжээгүй арга хэмжээ:**

Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбоотой нийт 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 10 буюу 13.5% нь хэрэгжээгүй байна. Үүнд: 2013-2016 онд их сургуулиудын нэгдсэн хотхоны дэд бүтцийг барьж байгуулан, зарим их дээд сургууль, шинжлэх ухааны судалгааны төвүүдийн тодорхой хэсгийг хотоос нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлэх" арга хэмжээг ХБХГ-т даалгасан боловч хүрэх түвшнийг оновчтой тогтоогоогүй, зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

2016-2020 онд авто замын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх" ННТГ-т даалгасан боловч тус арга хэмжээг АХБ-аас санхүүжилт цуцлагдсан, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй тул хэрэгжээгүй;


- "Нийтийн тээврийн үр өгөөжийг дээшлүүлэх мастер төлөвлөгөө шинээр боловсруулах" арга хэмжээг ННТГ-т даалгасан, санхүүжилтийг 2016-2020 оны нийслэлийн төсөвт саналаа хүргүүлсэн ч төсөв батлагдаагүй байна.

НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинэ дагуул хот, Богд уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах, ачаа тээврийн логистик төв байгуулах ажлуудын ТЭЗҮ хийх зэрэг 6 арга хэмжээ хэмжээ нь урт хугацаанд хэрэгжүүлэхээр байна.

### **НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн залгамж:**

НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалттай холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

**Дүрслэл 5. НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн залгамж халаа**



Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тогтвортой, тасралтгүй, залгамж НТАГ-2022/46-ШТА-ГА

чанартай байх зарчмыг баримтлахаар тусгасан. Гэтэл НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд өмнөх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 3 арга хэмжээг орхигдуулж, залгамж чанартай байх зарчмыг алдагдуулсан байна. Үүнд:

- НЗД-ын 2013-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан “Нийслэлд метро байгуулах асуудлыг шийдвэрлэж, нийтийн тээвэрт шинэ төрлийн шаттайгаар нэвтрүүлж, автобус, таксины парк шинэчлэлтийг хийх” арга хэмжээг 2016 оноос зогсоосон, 2016-2020 онд;
- НЗД-ын 2016-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөө боловсруулах”, “Нийтийн тээврийн үр өгөөжийг дээшлүүлэх мастер төлөвлөгөө шинээр боловсруулах” 2 арга хэмжээг 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус тусгаагүй байна.

Нийслэлээс баримталж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний 45 буюу 60.7% нь хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй арга хэмжээ байгаа нь зорилтод түвшнийг оновчтой тодорхойлоогүй, газрын асуудал болон зураг төсөвгүй баталсан, гэрээ хэлэлцээр удааширсан, санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан тусгагдаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталснаас шалтгаалсан байна. Цаашид бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлахдаа хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11<sup>16</sup>-д заасны дагуу төлөвлөх шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Нийслэлээс баримталж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний 39.3% нь хэрэгжсэн, 60.7% нь дутуу хэрэгжилттэй болон хэрэгжээгүй байна. Мөн зарим арга хэмжээний бодлогын тогтвортой байдлыг хадгалаагүй, залгамж чанар нь алдагдсан байна.

<sup>16</sup> 4.1.11 “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

## **Б. НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:** Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөнийг зохицуулах, ачаалал бууруулах чиглэлээр НЗДТГ, УБЗАА, ХБХГ, НЗХГ, ННТГ, ЗХУТ НӨТҮГ, ХСХГ, НГЗБА, НУБХАЗТБНТХН гэсэн байгууллагууд дүрэмд заасан чиг үүргийг дагнан болон хамтран хэрэгжүүлж байна.

Мөн нийслэлд газар, барилгажилтын асуудлыг хэлэлцэх “Мэргэжлийн зөвлөл” ажиллаж, 2013-2021 онд 5564 барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгожээ.

Замын хөдөлгөөний зохицуулалт, ачаалал бууруулах зорилгоор нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх, сургууль цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх, авто зам, замын байгууламж барих, явган хүний болон дугуйн зам нэмэгдүүлэх, замын хөдөлгөөн зохицуулах гэрэлтүүлэг болон камер нэмэгдүүлэх, газар чөлөөлөлтийн арга хэмжээ авах болон түр зуурын зохицуулалтын шинжтэй чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, дугаарын хязгаарлалт, ЕБС-иудын эхлэх, дуусах цагт өөрчлөлт оруулах, гэрлэн дохиогоор замын хөдөлгөөн зохицуулах, хөдөлгөөнд саад учруулсан болон зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг зөөж тээвэрлэх зэрэг арга хэмжээг авч байна.

2012-2021 онд Нийслэлийн авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр Улсын төсвийн хөрөнгөөр 413,601.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 339 ТАХ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 511,777.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 756 ТАХ, НЗСХ-өөр 306,883.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1810 ТАХ, нийт 1,232,262.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2905 ТАХ хэрэгжүүлэхээр баталжээ. Үүнээс 1,062,943.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1782 ТАХ хэрэгжжээ.

### **2.1. Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт үр дүнтэй байна уу?**

Нийслэлийн эрх бүхий байгууллагууд нь замын хөдөлгөөний зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээрх зорилт, арга хэмжээг уялдуулахгүйгээр оновчгүй төлөвлөж, хөгжлийн болон хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, бусад суурь шалтгааныг зөв тодорхойлоогүй, үйл ажиллагаагаа нэгдсэн байдлаар хэрэгжүүлээгүйгээс үр дүн хангалтгүй, улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, хандивын хөрөнгийн эх үүсвэрийн боломжийг үр дүнтэй ашиглаагүй байна. Жил ирэх тусам төлөвлөөгүй зардлууд нэмэгдэж, төсөвт хүндрэл учруулан замын хөдөлгөөн зохицуулалт, ачаалал буурах биш *“түгжрэл”, “тэг зогсолт хийх”, “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо”, “Монгол Улсын Сайд, түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга”, “Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээ буюу түгжрэлийн бууруулах 888.9 /420.0/ тэрбум төгрөг”, “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл”* гэх нэршил, нэгж, төсөв бий болтлоо өнөөдрийг хүрсэн үр дүнтэй байна.

#### **2.1.1. Нийслэлийн эрх бүхий байгууллагуудын бүтэц, чиг үүрэг уялдаатай байна уу?**

Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах, ачаалал бууруулах чиглэлээр тодорхой чиг үүргийг дагнан болон хамтран хэрэгжүүлж байгаа НЗДТГ, УБЗАА, ХБХГ, НЗХГ, ННТГ, ЗХУТ НӨТҮГ, ХСХГ, НГЗБА, НУБХАЗТБНТХН зэрэг байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа болон нийслэлд газар, барилгажилтын архитектур төлөвлөлтийн даалгаврыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн хэлэлцэх эрх бүхий “Мэргэжлийн зөвлөл”-ийн барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгож байгаа зохицуулалтыг аудитад хамруулаа. Үүнд:

Тус зөвлөл нь 2016 оноос хойш НЗД-ын шийдвэрээр 9-22 хүний бүрэлдэхүүнтэйгээр 9 удаа өөрчлөн зохион байгуулагдаж, үндсэн бүрэлдэхүүнд нь ХБХГ, НГЗБА голчлон оролцож байгаад 2021 оноос ХБХГ-ын даргын тушаалаар дүрэм шинэчлэн баталж хэлэлцэх асуудалд өөрчлөлт орж чиг үүргийг салгасан байна.

Дүрслэл 6. 2016-2022 онд Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцэх асуудал

| НЗД-ын захирамжаар баталсан мэргэжлийн зөвлөлийн хэлэлцэх асуудал           | ХБХГ-ын даргын тушаалаар баталсан мэргэжлийн зөвлөлийн хэлэлцэх асуудал |
|-----------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|
| Норм нормативд санал өгөх                                                   | Хот байгуулалтын баримт бичгийн эхний, дундын болон эцсийн тайлан       |
| Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх                     | Инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн төлөвлөлт                 |
| Инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн шийдэл           | Барилга байгууламжийн төлөвлөлт                                         |
| Авто зам гүүр, инженерийн бэлтгэл арга хэмжээ                               | Авто зам замын байгууламжийн төлөвлөлт                                  |
| Барилга байгууламж барих хүсэлт                                             | Тохижилт ногоон байгууламжийн төлөвлөлт                                 |
| Тохижилт ногоон байгууламжийн шийдэл                                        |                                                                         |
| Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө                             |                                                                         |
| Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд туссан барилга байгууламжийн газрын асуудал |                                                                         |
| Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах       |                                                                         |
| Газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах       |                                                                         |
| Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацаа сунгах   |                                                                         |
| Газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгуулах                            |                                                                         |
| Улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих                   |                                                                         |

2016-2022 онуудад зөвлөлийн бүрэлдэхүүнийг 11 байгууллагын төлөөллийг хамруулж 9 удаа өөрчлөн томилсон байна.

Дээрх зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХБХГ, НГЗБА-дад түшиглэн зохион байгуулж дэд бүтцийн байгууллагууд, мэргэжлийн болон салбарын бусад байгууллагуудын оролцоог жигд хангаагүй нь байгууллага хоорондын ажлын уялдаа хангагдахгүй байх, барилгын норм, дүрэм, стандарт зөрчигдөх нэг шалтгаан болж байна.

Дараах байгууллагуудын дүрмээр хүлээсэн зарим чиг үүрэг давхардсан байна.

Тухайлбал:

➤ УБЗАА-ны дүрмийн 4 дэх заалтын 4.3.17-д “Иргэн, хуулийн этгээдээс инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажил гүйцэтгэх зорилгоор авто зам, замын байгууламжийг эвдэх, сэтлэх сүвлэх, орц, гарц гаргах тохиолдолд журмын дагуу зөвшилцөх, зөвшөөрөл олгох, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэд хяналт тавих, ашиглалтад хүлээн авах” ЧИГ үүрэг нь НЗХГ-ын дүрмийн 4 дэх заалтын 4.1.8-д “авто зам, замын байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах, зогсоол хийх, инженерийн шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажилтай холбогдуулан зураг төсөлд санал өгөх, зөвшилцөх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох журмын дагуу зөвшөөрөл олгох, нөхөн сэргээх ажилд хяналт тавих”;

➤ ННТГ-ын дүрмийн 4 дэх заалтын 4.1.15-д “стандарт, шаардлага хангасан хүүхдийг болон ажилчдын автобус бусад тээврийн хэрэгслийг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчуулах, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах” чиг үүрэг нь ЗХУТ НӨТҮГ-ын дүрмийн 3<sup>17</sup> дэх заалтын 3.18-д “Хотын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн цахим бүртгэл хийх, холбогдох зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах”;

➤ НЗХГ-ын дүрмийн 4 дэх заалтын 4.1.2-д тусгагдсан ...авто зам, замын байгууламжийн зураг төсөл, зургийн даалгавар боловсруулах, батлуулах, санал өгөх” чиг үүрэг нь НХБХГ-ын дүрмийн 4<sup>18</sup> дэх заалтын 4.1.6-д тусгагдсан ...авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар боловсруулах, загвар зураг батлуулах”

➤ НЗХГ-ын дүрмийн 4 дэх заалтын 4.1.4-д “нийслэлийн авто замын хөдөлгөөнийг оновчтой төлөвлөх, түгжрэлийг бууруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачааллыг зохицуулах” чиг үүрэг нь ЗХУТ НӨТҮГ-ын дүрмийн 4 дахь заалтын 3.2-д “Замын хөдөлгөөний ажиглалт, тооллого хяналтын төхөөрөмж /камер, RFID систем болон бусад/-өөс ирүүлсэн тоон мэдээлэл, хөдөлгөөний бүрэн мэдээллийг үндэслэн судалгаа хийж, хөдөлгөөнийг оновчлох, зохион байгуулах” зэрэг чиг үүргүүд байна.

<sup>17</sup> 4. Төвийн үндсэн чиг үүрэг

<sup>18</sup> 4. Газрын үндсэн чиг үүрэг

Мөн зарим байгууллагуудын дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай албан тушаалтны орон тоо хүн томилогдоогүй сул байгаа бол зарим шаардлагатай албан тушаалтныг бүтцэд тусгаж батлаагүй байна. Үүнд:

➤ НЗД, ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны А/42, А/211 дүгээр “Нийслэлийн Газар зохион байгуулалтын албан дүрмийг шинэчлэн батлах тухай” захирамж, тушаалын 7<sup>19</sup> дахь заалтын 7.13.1-д “*нийгмийн зайлшгүй хэрэгцээ, улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын нөлөөлөлд өртсөн нэгж талбаруудын нөхөх олговруудын зориулалттай хөрөнгийн үнэлгээг хийлгэх, үнийн дүнг зөвшилцөх, зөвшилцсөн үнийн дүнгийн дагуу нөхөх олговор олгох, газар чөлөөлөх, солих буюу эргүүлэн авах арга хэмжээг зохион байгуулах*” зорилго, чиг үүрэг бүхий “Хөрөнгийн үнэлгээний мэргэжилтэн”-ий орон тоо сул;

➤ НЗД-ын 2022 оны А/115 дугаар захирамжаар баталсан ХБХГ-ын дүрмийн 4 дэх заалтын 4.1.6-д “*Барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар, нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын даалгавар боловсруулах, загвар зураг батлуулах*” чиг үүргийн “авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар”-ыг боловсруулах, хянах чиг үүрэг бүхий албан тушаалтныг бүтцэд тусгаж батлаагүй;

➤ НЗД-ын 2022 оны А/935 захирамжаар НУБХАЗТБНТХН НӨТҮГ-ын бүтцийг 27 орон тоотойгоор баталснаас өнөөдрийн байдлаар 17 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх байгууллагуудын чиг үүрэг давхардаж, зайлшгүй шаардлагатай орон тоо хүнгүй байгаагаас 1 чиг үүргийг 2 байгууллага зэрэг гүйцэтгэх, хуульд нийцээгүй шийдвэр гаргах, ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, хугацаа алдах зэрэг эрсдэл үүсэж байна. Тухайлбал:

Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар, нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын даалгавар боловсруулах, загвар зураг батлуулах чиг үүргийг ХБХГ хариуцахаар дүрэмд заасны дагуу 2012-2021 онд 136 гүүр, авто зам, замын ажлын зургийн даалгаврын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон байхад НЗХГ-аас тухайн онуудад 540 зургийн даалгаварт холбогдох байгууллагуудаас санал авчээ. Тус зургийн даалгаврын дагуу 204 замын ажил хийгдсэн байна. НЗХГ-аас дээрх зургийн даалгаварт ХБХГ-аас санал аваагүй хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна.

**Дүгнэлт:** НЗД нь газар, барилгажилтын “Мэргэжлийн зөвлөл”-ийг байгуулахдаа эрх бүхий байгууллагуудын оролцоог жигд хангаагүй, дүрэм батлахдаа зарим байгууллагын чиг үүргийг давхардуулсан байна.

## **2.1.2 Замын хөдөлгөөний зохицуулалтыг хүн ам, нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулсан уу?**

Нийслэлийн эрх бүхий байгууллагуудын замын хөдөлгөөн зохицуулах, ачаалал бууруулах чиглэлээр хүн ам, нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

### **Нийслэлд замын хөдөлгөөний өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах:**

Дээрх зорилгоор НЗД нь 2010 оны 292 дугаар захирамжаар “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨТҮГ-ыг байгуулжээ.

Тус ЗХУТ нь өнөөдрийн байдлаар 6 хэлтэс, 94 албан хаагчтайгаар явган болон авто замын 155 гэрлэн дохио, 44 хяналтын камер, 56 зөрчил илрүүлэх төхөөрөмжөөр 120-ын мянгат, 5-ын шар, Чулуун овооны тойрог, Хайлаастын уулзвараас хотын төв рүү чиглэсэн ачаалал ихтэй 78.14 км нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтыг хийж байна.

<sup>19</sup> 8.1 Удирдлага болон хэлтсүүдийн үндсэн чиг үүрэг

Мөн ТЦА-тай хамтран 2017 онд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний мэдээллийг илүү ухаалаг байдлаар хэрэглэгчдэд мэдээлэх явах цэг, хүрэх цэгээ сонгосноор жолооч, зорчигчдод ачаалалтай зам уулзваруудыг мэдээлэх эсвэл тойруу замаар ачаалалгүй явах замыг санал болгох үйлчилгээ бүхий “Ubtraffic” аппликейшн, 2018 онд замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, зөрчлийг бууруулах, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “E-Police” аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглаж эхэлснээр тус төвийн замын хөдөлгөөний зөрчил, саад илрүүлэлт 2018-2022 онуудад 5%-иар нэмэгдсэн байна. Тухайлбал: 2013-2022 онуудад замын хөдөлгөөний 4,243,885 зөрчил илрүүлж, 51,027.6 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Хүснэгт 6. ЗХУТ-өөс илрүүлсэн зөрчил, торгуулийн мөнгөн дүн**

| №           | Хамрах огноо | Хяналтын телекамераар илрүүлсэн |                 | Е-police аппликейшнээр илрүүлсэн |                |              |                |
|-------------|--------------|---------------------------------|-----------------|----------------------------------|----------------|--------------|----------------|
|             |              | Зөрчлийн тоо                    | Мөнгөн дүн      | Баталгаажсан                     |                | Биелэлт      |                |
|             |              |                                 |                 | Зөрчлийн тоо                     | Мөнгөн дүн     | Зөрчлийн тоо | Мөнгөн дүн     |
| 1           | 2013         | 77029                           | 425.2           | -                                | -              | -            | -              |
| 2           | 2014         | 363476                          | 1,852.8         | -                                | -              | -            | -              |
| 3           | 2015         | 445823                          | 2,193.8         | -                                | -              | -            | -              |
| 4           | 2016         | 385848                          | 3,478.5         | -                                | -              | -            | -              |
| 5           | 2017         | 348633                          | 4,317.7         | -                                | -              | -            | -              |
| 6           | 2018         | 324454                          | 5,015.5         | 697                              | 13.5           | 593          | 11.2           |
| 7           | 2019         | 566220                          | 5,779.0         | 10796                            | 195.1          | 9070         | 161.0          |
| 8           | 2020         | 373116                          | 6,659.2         | 10557                            | 180.3          | 8555         | 139.3          |
| 9           | 2021         | 625187                          | 13,017.8        | 35263                            | 692.6          | 18915        | 360.9          |
| 10          | 2022         | 734099                          | 8,288.1         | 72753                            | 1,469.7        | 17630        | 356.5          |
| <b>Нийт</b> |              | <b>4243885</b>                  | <b>51,027.6</b> | <b>130066</b>                    | <b>2,551.2</b> | <b>54763</b> | <b>1,028.9</b> |

Дээрх аппликейшнийг нэвтрүүлснээр нийслэл хотын замын хөдөлгөөний нөхцөл байдлыг иргэдэд цаг алдалгүй хүргэж, замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн сайн жишээ болсон байна.

2010-2022 онуудад хөдөлгөөн мэдрэгч 52 төхөөрөмжөөс давхардсан тоогоор 260, зөөврийн тоологч төхөөрөмжөөр 130, хяналтын телекамераар 410 нийт 592 удаа уулзвар, замд хөдөлгөөний эрчмийн тооллого судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлж 2011-2022 онуудад хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионы горимын өөрчлөлтийг нийт 638 удаа хийжээ.

Цаашид замын хөдөлгөөнд хяналт зохицуулалт хийхэд 104 байршилд хяналтын телекамер, 16 байршилд уулзарын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, 25 байршилд явган зорчигчийн гэрлэн дохио, 25 байршилд хурдны зөрчил илрүүлэх зөрчлийн камер, 36 байршилд улаан гэрлийн зөрчил илрүүлэх зөрчлийн камер нэмж суурилуулснаар Их тэнгэр ам, Буянт Ухаа 1 хороолол, 22-ын товчоо, Баянхошууны хуучин тойрог, Хайлаастын эцэс, Дамбын тойрог, Шархадын эцсээс хотын төв рүү чиглэсэн ачаалал ихтэй хотын төвийн 6 дүүргийн 153.18 км нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтыг хийх боломжтой урьдчилсан тооцоог хийсэн байна.

**Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, улсын дугаарын хязгаарлалт:**

НЗД нь 2012 оноос Улаанбаатар хотын авто замын хэт ачааллаас урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгслийг улсын дугаарын хязгаарлалтаар зохицуулах арга хэмжээг авч эхэлсэн байна.

Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ:

- БГД, СБД, БЗД-үүдийг хамарсан төв зам буюу 5-н шараас офицеруудын тойрог хүртэл улсын дугаарын хязгаарлалтыг замын ачаалал ихтэй төвийн 6 дүүрэгт авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:
- Их тойруугийн зам болон түүний доторх замуудад,

- Энхтайваны өргөн чөлөөнд Саппорогийн уулзвараас Чулуун овооны уулзвар хүртэлх хэсэгт,
- Чингисийн өргөн чөлөөнд 120 мянгатын уулзвараас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх хэсэгт,
- Энэбишийн өргөн чөлөөнд Ахуй үйлчилгээний ордны уулзвараас Баянбүрдийн аюулгүйн тойрог хүртэлх хэсэгт,
- Ард Аюушийн өргөн чөлөөнд Ахуй үйлчилгээний ордны уулзвараас Саппорогийн уулзвар хүртэлх хэсэгт,
- Нарны зам болон түүний доторх замуудад,
- Чингэлтэйн өргөн чөлөөнд 32-ын тойрог,
- Доржийн гудамж КТМС-ийн баруун урд аюулгүйн тойрог,
- Их хүрээ гудамж Дүнжингаравын уулзвар,
- Их Монгол Улсын гудамж Хоум плазагийн уулзвар,
- Энгельсийн гудамж МИС-ын уулзвар,
- Ажилчдын гудамж ТЭЦ-4 уулзвараас дотогш ажлын өдрүүдэд 08<sup>00</sup>-20<sup>00</sup> цагийн хооронд замын хөдөлгөөнд оролцохыг хязгаарлажээ.

### **Нийслэлийн ЕБС-ийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулах:**

НЗД-ын 2022 оны А/217 дугаар “Нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагт зохицуулалт хийх тухай” захирамжаар замын хөдөлгөөний ачаалал ихтэй БЗД-ийн 15, СБД-ийн 21, ЧД-ийн 8, ХУД 15 нийт төр, хувийн хэвшлийн 59 ЕБС-иудын хичээл эхлэх, дуусах цагт өөрчлөлт оруулжээ.

**Дүгнэлт:** Нийслэлд замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр хөдөлгөөний ачаалал ихтэй байшрлуудад нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

### **2.1.3 Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна уу?**

Нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулах, ачаалал бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

### **Нийтийн тээврийн парк шинэчлэлийг хийж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

Нийслэлийн хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд нийслэлийн өмчийн 2 ОНӨААТҮГ, хувийн хэвшлийн 17 ААНБ нийт 1289 автобустайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2009-2022 онуудад “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ 4 удаа, ЗТН 7 удаа парк шинэчлэлт хийсэн бол ААНБ-уудын хувьд 2016 оноос парк шинэчлэл үндсэндээ хийгээгүй байна.


**Хүснэгт 7. Нийтийн тээврийн автобусны мэдээлэл**

| №  | ААНБ-ын нэр                   | Хамрах огноо |      |      |      |      |      |      |      |      |      |      |      |      |      | Нийт дүн |
|----|-------------------------------|--------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|----------|
|    |                               | 2009         | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |          |
| 1  | Авто терминал трейд ХХК       | 5            | 8    | 18   | 2    | 4    | 5    |      |      |      |      |      |      |      |      | 42       |
| 2  | Автобус нэгдэл ХХК            | 7            | 3    | 10   |      | 1    | 4    |      |      |      |      |      |      |      |      | 25       |
| 3  | Аз сервис ХХК                 | 6            |      |      |      |      |      |      |      |      |      |      |      |      |      | 6        |
| 4  | БЛЮБУС ХХК                    | 8            | 9    | 9    | 5    | 9    | 1    |      |      |      |      |      |      |      |      | 41       |
| 5  | Буурал мянган                 |              |      | 1    | 1    |      |      |      | 2    |      | 2    |      |      |      |      | 6        |
| 6  | ГБУС ХХК                      |              | 2    | 16   |      |      |      |      |      |      |      |      |      |      |      | 18       |
| 7  | ДЮЦ ХХК                       | 5            |      | 12   | 1    | 6    | 2    |      |      |      |      |      |      |      |      | 26       |
| 8  | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 18           |      |      |      |      | 6    | 25   |      |      |      | 1    |      | 46   |      | 96       |
| 9  | ЗТН ОНӨААТҮГ                  | 178          |      | 3    | 6    | 13   | 10   | 18   |      |      |      | 8    |      |      | 60   | 296      |
| 10 | Мяралзаа ХХК                  | 8            | 3    | 17   | 9    | 2    | 4    |      |      |      |      |      |      |      |      | 43       |
| 11 | Сайхан ирээдүй ХХК            | 8            | 10   | 2    |      |      |      |      |      |      |      |      |      |      |      | 20       |
| 12 | Сутайн Буянт ХХК              | 18           | 11   | 36   | 6    | 6    |      |      | 11   |      |      |      |      |      |      | 88       |
| 13 | Трансбус ХХК                  | 8            | 26   | 34   | 17   | 17   | 6    | 1    | 2    |      |      |      |      |      |      | 111      |

|    |                          |            |            |            |            |            |           |           |           |          |          |          |          |           |           |             |
|----|--------------------------|------------|------------|------------|------------|------------|-----------|-----------|-----------|----------|----------|----------|----------|-----------|-----------|-------------|
| 14 | Тэнүүн - Огоо ХХК        | 45         | 16         | 27         | 16         | 14         | 6         |           |           |          |          |          |          |           |           | 124         |
| 15 | Тэнүүн-Огоо 3-р бааз ХХК | 4          | 7          | 46         |            | 1          | 2         |           |           |          |          |          |          |           |           | 60          |
| 16 | Үнэгтийн уул ХХК         |            | 3          | 5          |            | 2          |           |           |           |          |          |          |          |           |           | 10          |
| 17 | Эмсид ХХК                | 12         | 10         | 18         | 2          |            | 1         |           |           |          |          |          |          |           |           | 43          |
| 18 | Эрдэм транс ХХК          | 25         | 13         | 34         | 40         | 56         | 30        | 14        | 6         |          |          |          |          |           |           | 218         |
| 19 | Эс энд Эй Транс ХХК      |            |            | 4          |            | 3          |           |           | 9         |          |          |          |          |           |           | 16          |
|    | <b>Төрийн</b>            | <b>196</b> | <b>0</b>   | <b>3</b>   | <b>6</b>   | <b>13</b>  | <b>16</b> | <b>43</b> | <b>0</b>  | <b>0</b> | <b>0</b> | <b>9</b> | <b>0</b> | <b>46</b> | <b>60</b> | <b>392</b>  |
|    | <b>Хувийн</b>            | <b>159</b> | <b>121</b> | <b>289</b> | <b>99</b>  | <b>121</b> | <b>61</b> | <b>15</b> | <b>30</b> | <b>0</b> | <b>2</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b>  | <b>0</b>  | <b>897</b>  |
|    | <b>Нийт дүн</b>          | <b>355</b> | <b>121</b> | <b>292</b> | <b>105</b> | <b>134</b> | <b>77</b> | <b>58</b> | <b>30</b> | <b>0</b> | <b>2</b> | <b>9</b> | <b>0</b> | <b>46</b> | <b>60</b> | <b>1289</b> |

Монгол улсын стандарт MNS 5012 : 2021 “Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага”-ын 10.8<sup>20</sup>-д заасан стандартын дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй автобусны насжилтыг авч үзвэл нийт автобусны 36.9% буюу 476 нь 2022 онд, 22.7% буюу 292 нь 2023 онд, 8.1% буюу 105 нь 2024 онд ашиглалтын хугацаа нь дуусахаар байна. Энэ нь нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй нийт автобусны 67.7% нь байна.

**График 2. Нийтийн тээврийн насжилт**



Судалгаанаас дүнгээс харвал Аз сервис ХХК, ГБУС ХХК, Сайхан ирээдүй ХХК, Эмсид ХХК-ийн нийт 87 автобусны ашиглалтын хугацаа дууссан, нийт ААНБ-ын автобусны 73.6% нь 10-аас дээш жил ашигласан нь цаашид гэрээний дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүйд хүрэхээр байхад ННТГ-аас гэрээний хугацаа дуусаагүй, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд

оролцох боломжгүй гэх тайлбарыг хийж байгаа нь үндсэн зорилго чиг үүргээ ойлгоогүй байна.

### **ЕБС-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд 244 ЕБС-д 312120 хүүхэд суралцаж байгаагаас 202198 суралцагч буюу 64.8% нь хамран сургах тойргийн, 109922 суралцагч буюу 35.2% нь хамран сургах тойргийн бус хүүхэд байна.

**График 3. Нийслэлийн төвийн 6 дүүргийн ЕБС-ийн хамран сургах болон хамран сургах бус тойргийн суралцагчдын мэдээлэл**




Хамран сургах тойргийн бус хүүхэд СБД-ийн сургуулиудад хамран сургах хүүхдийн тооноос давсан, ЧД, ХУД-ийн сургуулиудад хамран сургах хүүхдийн тооноос 6.7%-11.5%-иар бага байна.

<sup>20</sup> “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 12-аас дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно”

Нийслэлд 2021-2022 оны хичээлийн жилд 293 ЕБС-д 39303 сурагч нэгдүгээр ангид элсэн суралцаж, 29442 сурагч төгссөн байна. 2012-2023 онуудын хичээлийн жилд элсэн суралцсан болон төгссөн сурагчдын харьцуулан үзвэл:


**График 4. ЕБС-д элссэн болон төгсөгчдийн харьцаа**



Статистикаас харвал жилд дунджаар 31508 сурагч нэгдүгээр ангид элсэж, 23358 сурагч төгсөж байна. Элсэн суралцагчдын тоо төгссөн сурагчдаас дунджаар 8150-иар их байна. Энэ нь жилдээ 2 ээлжээр хичээллэнэ гэж тооцвол ойролцоогоор 1200 хүүхдийн суудалтай 4, 860 хүүхдийн суудалтай 6 сургууль шаардлагатай байна.

2012-2021 онд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 59 сургууль болон сургууль цэцэрлэгийн цогцолбор барихаас 41 сургууль, цэцэрлэгийн цогцолбор баригдаж, 18 сургууль ашиглалтад ороогүй он дамжин хэрэгжиж байна. Энэ нь сургууль барихаар төлөвлөсөн нийт ТАХ-ний 30.5% байна.

**График 5. 2012-2021 онд шинээр баригдсан сургуулийн тоо**




Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 16 сургууль, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 2 сургууль нийт 18 сургуулийн ТАХ хэрэгжилт удааширч зогссон байна. Нийслэлийн хэмжээнд жилдээ зөвхөн шинээр элсэн суралцаж байгаа сурагчдын тооноос хамаарч дунджаар 6 сургууль шаардлагатай байхад 2012-2021 онд жилд дунджаар 4 буюу нийт 41 сургууль ашиглалтад орсон нь сургуулийн хүртээмжийг бодитойгоор нэмэгдүүлж чадаагүй байна.

**Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд 641 СӨБ-ын байгууллагад 80346 хүүхэд хамрагдаж байна. Статистикийн мэдээллээр жилд дунджаар 2-5 насны

хүүхэд 139693 байхад СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 34557 буюу 2-5 настай хүүхдийн 24.7 %-ийг эзэлж байна.

**График 6. 2015-2022 онд СӨБ-д элсэн суралцаж буй хүүхдүүдийн мэдээлэл**



2012-2021 онд улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 15685 хүүхдийн суудалтай 89 цэцэрлэг барихаас барихаар төлөвлөснөөс 15085 хүүхдийн суудалтай 73 цэцэрлэг ашиглалтад орж, 2230 хүүхдийн суудалтай 12 цэцэрлэг ашиглалтад ороогүй он дамжин хэрэгжиж байна. Энэ нь 2012-2021 онд цэцэрлэгт хамрагдах шаардлагатай нийт хүүхдийн 10.8%-ийг эзэлж байна. Сүүлийн 10 жилд баригдсан цэцэрлэгийн тоо цэцэрлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн дөнгөж 10% байгаа нь хүн амын тоотой уялдуулж үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлээгүйг харуулж байна.

### **Газар чөлөөлөлт:**

2012-2022 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний хүрээнд газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн нэгж талбарын нөхөн олговорт **246,528.4** сая төгрөгийг олгожээ.

**График 7. 2012-2022 онд газар чөлөөлөлтөд зарцуулсан санхүүжилт**




Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжилтэд тавих хяналт сайн, батлагдсанаас хойш газар олголтыг төлөвлөгөөнд нийцүүлэн олгодог бол дээрх зардлыг бага хэмжээгээр төлөвлөх, цаашилбал гаргахгүй байх боломжтой байжээ.

Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, замын болон бусад сангийн эх үүсвэрээр хэрэгжих ТАХ болон 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлууд газар чөлөөлөлтийн асуудлаас болж гацаж, хэрэгжилт удааширч байна. Үүнийг жишээлбэл:

“Улаанбаатар хотын 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичигт Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам болон Наадамчдын авто замаас Энх тайвны өргөн чөлөө хүртэлх авто замыг барихад 355 нэгж талбарыг чөлөөлөхөөр тус баримт бичгийн 3.3.1-т тусгагдаж төлөвлөгдсөн.

Гэтэл ерөнхий төлөвлөгөө батлагдсанаас хойш тус замын нөлөөллийн бүсэд өмчлөхөөр 94, эзэмшихээр 31, ашиглуулахаар 4 нийт 129 нэгж талбарыг иргэн, ААНБ-д шинээр олгожээ.

**Дүрслэл 7. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагад төлөвлөгдсөн 2 гол замын нөлөөлд өртсөн байдал**



/Эх сурвалж: ХБХГ/

Энэ нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд чөлөөлж дахин төлөвлөлтөөр авто зам барихаар төлөвлөгдсөн байхад газар олголт хийсэн нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчсөн байна. Үүнээс шалтгаалж өнөөдрийн ханшаар төсөөллийн үнэлгээг хийхэд 70,406.9 сая төгрөгийг нөхөн олговорт олгох эрсдэл үүссэн байна. (Толгойт-Аюуш авто замын газар чөлөөлөлтийн үнээр тооцов)

НГЗБА-аас тухай бүсэд газар олгосон нь иргэдийн өмчлөх эрхийг хязгаарлах боломжгүй гэсэн тайлбар хийж байгаа ч түгжрэлийн асуудал нь Нийслэлчүүдийн тулгамдсан асуудал болсон байгаа нь хамааралтай юм.

Мөн 2021-2022 онд он дамжин хэрэгжиж байгаа авто зам барих ТАХ-ний 1,780.7 сая төгрөгийг түгжрэл бууруулах чиглэлээр батлагдсан төсвөөс НЗД-ын захирамжаар газар чөлөөлөлтөд нөхөн санхүүжүүлсэн байна.

2022 онд хэрэгжүүлэх түгжрэл бууруулахад чиглэл 5 чиглэл бүхий ТАХ-ний гол зам барих болон хөгжлийн төслүүдийн газар чөлөөлөлтийн ажил эхлээгүй, бусад 3 арга хэмжээний газар чөлөөлөлтийн ажил 50%-56%-тайгаар ТАХ хэрэгжээгүй хүлээлтийн байдалд байна.

**График 8. Газар чөлөөлөлтийн байдал**



Газар чөлөөлөлтийн ажил удаашралтай байгаа нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, ААНБ-ын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсон байх хуулийн заалтыг мөрдөөгүй, ТАХ-г батлахдаа төсвийн тухай хуулийг зөрчиж шаардлага хангасан ТАХ-г батлаагүйтэй холбоотой байна.

ГТХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно”, МУИГӨТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргахаас нэгээс доошгүй жилийн өмнө газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар өмчлөгчтэй энэ тухай урьдчилан тохиролцсон байна” гэж заасныг зөрчиж ТАХ-г хэрэгжүүлэх хугацааг газар чөлөөлөлттэй зэрэгцүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаас ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гэтэл ТАХ-ээг газар чөлөөлөлтийн ажилтай хамтад нь төсөвт тусгаснаас шалтгаалж ТАХ-ний хэрэгжилтийн үе шатны ажил удааширч, хэрэгжих хугацаанд нөлөөлөх үр дагаварыг үүсгэж байна.

ТАХ-ний гүйцэтгэгч шалгараагүй, иргэн, ААНБ-тай тохиролцоонд хүрээгүй, НЗД-ын газар чөлөөлөх захирамж гараагүй гэсэн шалтгаануудаас хамаарч 254 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдээгүй байна.

#### **Авто зам, замын байгууламж:**

2012-2021 онд авто зам, замын байгууламжийн ажилд 548,186.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2043 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ. Үүний 6.1% нь авто зам гүүр барих, 6.6% нь авто замын зураг төсөл боловсруулах, 8.8% нь явган болон дугуйн зам барих, 78.6% нь зам засвар арчлалт байна.

Дээрх онуудад авто замын зураг төсөл боловсруулахаар 17,341.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 135 ТАХ-г баталсан. Үүнээс авто замын 31 зураг төслийн дагуу замын ажил хийгдсэн байна. Энэ нь нийт зураг төсвийн 22.9% нь байна.

**График 9. Авто замын зураг төсөө боловсруулах ТАХ**



Авто замын зураг төсөл боловсруулж авто зам барихаар 135 ТАХ-г баталснаас 70% нь буюу 6,110.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 ТАХ нь зураг төслийн шатандаа явж байна. Үүний 307.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 замын зураг төсөл 2016 оноос одоог хүртэл боловсруулагдаж дуусаагүй байна. Авто замын зураг төсөл боловсруулагдсан хэдий ч 291.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6

ТАХ-ны авто замын ажил нь газар чөлөөлөлт хийгдээгүй, төсөв байхгүй шалтгаанаар хийгдээгүй байна.

### **Тээврийн хэрэгслийн 1-р эгнээ, дугаарын хязгаарлалт:**

НЗД-ын 2012 оны А/532 дугаар “Улаанбаатар хотын автозамын хэт ачааллаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авах тухай” захирамжаар тээврийн хэрэгслийг улсын дугаарын хязгаарлалтаар зохицуулах арга хэмжээг анх журамлаж 2020 оны А/1037 дугаар захирамжаар “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн улсын дугаараар ялгаж замын хөдөлгөөнд оролцуулах цаг, нутаг дэвсгэрийн бүсчлэл”-г тус тус шинэчлэн баталсан байна.

Аудитаар НТГ-аас чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчиж буй нийтийн тээврийн үйлчилгээний ашиглалтын хурдны хугацааг нийслэлийн хүн амын төвлөрөл ихтэй БГД, СБД, БЗД-ээр дамжин өнгөрдөг Ч:1 “5 шар-Офицеруудын ордон” чиглэлд үйлчилгээ үзүүлдэг автобусны ашиглалтын хурдыг тооцоолуулахад дараах үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 8. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:1 “5 шар- Офицеруудын ордон” чиглэлийн ашиглалтын хурдны судалгаа**


| №           | Сар | Огноо |      |      |      |      |      |
|-------------|-----|-------|------|------|------|------|------|
|             |     | 2017  | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
| 1           | 1   | -     | 11.9 | 11   | 12.3 | 13.2 | 12.3 |
| 2           | 2   | -     | 11.1 | 11.4 | 12.3 | 15.4 | 12.1 |
| 3           | 3   | -     | 11.7 | 11   | 13   | 13   | 11.7 |
| 4           | 4   | -     | 11.4 | 10.9 | 12.8 | 15.7 | 11.7 |
| 5           | 5   | -     | 11   | 10.5 | 13.2 | 13.3 | 11.5 |
| 6           | 6   | -     | 11.1 | 11.3 | 13.2 | 13.1 | 11.7 |
| 7           | 7   | -     | 11.3 | 11.6 | 12.8 | 13.3 | 12.5 |
| 8           | 8   | 12.2  | 10.4 | 11.1 | 12.3 | 12.7 | 11.7 |
| 9           | 9   | 11.3  | 9.3  | 10.5 | 11.5 | 12.4 | 10.7 |
| 10          | 10  | 10.9  | 10   | 10.2 | 10.4 | 11.6 | 10.5 |
| 11          | 11  | 10.4  | 10.5 | 10   | 11.9 | 11.6 | -    |
| 12          | 12  | 10.8  | 9.6  | 10.5 | 13.2 | 10.8 | -    |
| Дундаж хурд |     | 11.1  | 10.7 | 10.8 | 12.4 | 13   | 11.6 |

Судалгаанаас харахад 2018-2021 онд автобусны дундаж хурд 0.1-2.3 болж өссөн ч 2022 онд тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байна.

Мөн ЗХУТ НӨТҮГ-аас 2022 оны 09 дүгээр сард хийсэн судалгаагаар бүртгэлийн камерт бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоог улсын дугаарын сүүлийн орон тэгш, сондгойгоор ангилан замын хөдөлгөөнд оролцуулсан үе буюу 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийг 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдөртэй, улсын

дугаарын сүүлийн оронгоор ангилан ажлын өдрүүдэд замын хөдөлгөөнд оролцуулсан үе буюу 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийг 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдөртэй харьцуулжээ.

**График 10. Улсын дугаарын сүүлийн орон тэгш, сондгой болон сүүлийн оронгоор ангилан ажлын өдрүүдэд замын хөдөлгөөнд оролцуулсан тээврийн хэрэгслийн тоо**



Дээрх мэдээллээс харахад улсын дугаарын сүүлийн орон тэгш, сондгойгоор ангилан замын хөдөлгөөнд оролцуулсан үед тээврийн хэрэгслийн тоо 35.3%-иар буурсан, улсын дугаарын сүүлийн оронгоор ангилан ажлын өдрүүдэд замын хөдөлгөөнд оролцуулсан үед 11%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.

### **Сургуулийн автобус төсөл:**

МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.13-т, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7-д “Сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлж, суралцагч гэр сургуулийн хооронд үнэ төлбөргүй зорчих “Сургуулийн автобус” төсөл хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнтэй холбогдуулан НЗД-ын 2019 оны А/1294 дүгээр “Хүүхдийн автобусны талаар авах зарим арга хэмжээний тухай”, А/1298 дугаар “Сургуулийн автобус төсөл хэрэгжүүлэх тухай” захирамж гарч хэрэгжиж эхэлсэн байна.

Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд хүүхдийн автобустай ерөнхий боловсролын төрийн 36, хувийн хэвшлийн 28 сургуульд нийтдээ 277 автобус хүүхэд тээвэрлэж байна.

**Хүснэгт 9. Нийслэлийн ЕБС-ийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй автобусны тоо, түүний насжилт**

| №  | Дүүрэг, хариуцах байгууллагын нэр | Сургуулийн тоо |               | Автобусны тоо |               |
|----|-----------------------------------|----------------|---------------|---------------|---------------|
|    |                                   | Төрийн өмчийн  | Хувийн өмчийн | Улсын         | Хувийн хэвшил |
| 1  | ННТГ                              | -              | -             |               | 23            |
| 2  | БГД                               | 4              | -             | 5             | -             |
| 3  | БЗД                               | 10             | 9             | 12            | 24            |
| 4  | БХД                               | 1              | -             | 3             | -             |
| 5  | СБД                               | 7              | 8             | 12            | 24            |
| 6  | СХД                               | -              | -             | -             | -             |
| 7  | ХУД                               | 6              | 10            | 7             | 157           |
| 8  | ЧД                                | 6              | 1             | 2             | 6             |
| 9  | БНД                               | 1              | -             | 1             | -             |
| 10 | НД                                | 1              | -             | 1             | -             |
|    | <b>Нийт</b>                       | <b>36</b>      | <b>28</b>     | <b>66</b>     | <b>211</b>    |

Нийслэлийн хэмжээнд нийт 293 ЕБС-аас 64 ЕБС буюу 21.8% нь хүүхдийн автобустай, нийт автобусны 76.2% нь хувийн хэвшлийн ЕБС-иудад байна.

Төрийн өмчийн 66 автобусны 25 автобусыг хүүхдийн автобус төслийн хүрээнд нийлүүлж 25 чиглэлд өдөрт дунджаар давхардсан тоогоор 4184-4300 хүүхэд тээвэрлэж байна.

Цаашид НБГ-аас хийсэн сурагчдын судалгаанд үндэслэн 2022-2023 оны хичээлийн жилд 55 сургуулийг хамруулан 63 чиглэлд 75 автобус явуулах саналыг ННТГ-т хүргүүлсэн байна.

### **Нийслэлийн ЕБС-ийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулах:**


НЗД-ын 2022 оны А/217 дугаар “Нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагт зохицуулалт хийх тухай” захирамжаар замын хөдөлгөөний ачааллыг бууруулахаар төрийн өмчийн 23, төрийн бус өмчийн 36 сургуулийн хичээл эхлэх цагт өөрчлөлт оруулсан байна. Дээрх 59 сургуулийн 83396 суралцагчдаас зорчих хөдөлгөөний судалгаа авахад 23952 буюу 28.1% нь хувийн унаа болон такси үйлчилгээгээр сургуульдаа зорчдог судалгаа гарчээ.

Сургуулиудын байршил, зорчих хөдөлгөөний урсгалаар бүсчлэн тухайн сургуулийн санал дээр үндэслэн:

- Өглөө 7:45, өдөр 13:15 цагт төрийн өмчийн 13, төрийн бус өмчийн 14 нийт 27 сургуулийн хичээлийг эхлүүлэх. Үүнд 48395 сурагч буюу нийт сурагчдын 14.2 хувь;
- Өглөө 8:15 цагт төрийн өмчийн 9, төрийн бус өмчийн 10, өдөр 13:45 цагт төрийн өмчийн 9, төрийн бус өмчийн 6 нийт 15 сургуулийн хичээлийг эхлүүлэх. Үүнд 30250 буюу нийт сурагчдын 8.9 хувь;
- Өглөө 9:00 цагт 1 ээлжтэй төрийн өмчийн 1, төрийн бус өмчийн 12 нийт 13 сургуулийн хичээлийг эхлүүлэх. Үүнд 4751 буюу нийт сурагчдын 1.4 хувь нь хамрагдсан.

Хичээлийн хуваарьт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хөдөлгөөний ачааллын бууралтыг тооцохоор ЗХУТ-өөс өглөөний 06-10 цагийн хооронд Баруун 4 зам, Хүүхдийн 100 /45 сургууль/, Цэцэг төв, Нарны замаас цирк рүү эргэх /Сант сургууль/ гэх мэт уулзварт байрлах бүртгэлийн камераар тээврийн хэрэгслийн тоонд үндэслэн судалгаа хийжээ.

**График 11. Бүртгэлийн камерт бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо /давхардсанаар/**



Дээрх судалгаанаас харахад замын хөдөлгөөний ачаалал бага үе буюу 06<sup>00</sup>-07<sup>00</sup> цагийн хооронд ачаалал 23.4% нэмэгдсэн бол ачаалал их үе буюу 07<sup>00</sup>-10<sup>00</sup> цагийн хооронд ачаалал -17.3%-иас -21.7% болж буурчээ.

Цаашид ЕБС-ийн хичээлийн цагийг өөрчлөхөд замын хөдөлгөөний ачаалал тодорхой цагуудад буурч байгаа эерэг өөрчлөлт гарсантай холбогдуулан ААНБ-иудын ажлын цагт

өөрчлөлт оруулах, зарим өдрүүдэд цахимаар ажиллах боломжуудыг судлах нь зүйтэй байна.

### **Нийслэлийн замын хөдөлгөөний ачааллыг бууруулах судалгаа:**

2010-2022 ондуудад НЗДТГ болон түүний харьяа байгууллага, олон улсын байгууллага, ТББ-уудаас хамтран замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр 22 төрлийн дэлгэрэнгүй судалгаа хийсэн байна.

Судалгаа хийсэн чиглэлээс харвал 2010-2018 он хүртэл хийгдсэн судалгаа нь нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, метро үйлчилгээнд нэвтрүүлэх болон хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөнд чиглэж байсан бол 2018 оноос хойш замын

хөдөлгөөний түгжрэлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох ачааллыг буруулах боломжийг судлах чиглэлээр хийгдсэн байна.

Аудитаар дээрх судалгааны дүнд үндэслэн замын хөдөлгөөний түгжрэл үүсгэж буй шалтгааныг эрэмбэлэхэд дараах төрлийн шалтгаан нь түгжрэлийг голчлон үүсгэсэн дүн гарчээ. Үүнд:

- Хот төлөвлөлт муу, томоохон зах худалдааны төвүүд нь хотын төвдөө байрладаг, хотхон хорооллын төлөвлөлт муугаас орц гарцгүй, газар эзэмших, өмчлөх эрхийн зөрчил
- Сургууль цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй, чанартай сургууль цэцэрлэг нь хотын төвдөө төвлөрсөн, шилжилт хөдөлгөөн их
- Уулзвар гол замын ойролцоох томоохон худалдааны төвүүд байрладаг, гол болон туслах авто замын хүрэлцээгүй байдал
- Авто зогсоолын хомсдол
- Нийтийн тээврийн автобусны хүрэлцээ, чиглэлийн оновчтой бус байдал
- Явган болон дугуйн замын сүлжээний асуудал
- Автомашины өсөлт, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт хангалтгүй, жолоочийн ур чадвар соёл муу гэж дүгнэсэн байна.

Аудитаар түгжрэл үүсгэж буй дээрх шалтгааныг судалж, хэрэгжилтийг үзэхэд ерөнхий төлөвлөгөө боловсруулахдаа суурь үзүүлэлтийг дутуу тооцож хугацаандаа хэрэгжих боломжгүй байдалд хүргэсэн, батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүй, холбогдох мэргэжлийн байгууллагууд хоорондоо уялдаа холбоогүй ажилласан байна. Тухайлбал:

Нийслэлийн хэмжээнд 2013-2021 онд 5564 барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосны 23.6% нь БЗД, 20.4% ХУД, 18.4% СХД, 13.5% нь БГД, 11.4% нь СБД, 6.7% ЧД, 5.7% нь алслагдсан дүүргүүдэд олгосон байна.

**Хүснэгт 10. 2013-2021 онд олгосон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ**

| №        | Дүүрэг | Нийт олгосон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний тоо | Үүнээс |                 |           |          |         |
|----------|--------|----------------------------------------------------------|--------|-----------------|-----------|----------|---------|
|          |        |                                                          | ИШС    | Засвар тохижилт | Цахилгаан | Авто зам | Барилга |
| 1        | БГД    | 751                                                      | 37     | 37              | 170       | 20       | 487     |
| 2        | БЗД    | 1313                                                     | 50     | 113             | 372       | 25       | 753     |
| 3        | СБД    | 637                                                      | 29     | 51              | 177       | 15       | 365     |
| 4        | СХД    | 1025                                                     | 47     | 61              | 580       | 9        | 328     |
| 5        | ХУД    | 1134                                                     | 63     | 40              | 396       | 17       | 618     |
| 6        | ЧД     | 376                                                      | 33     | 43              | 90        | 9        | 201     |
| 7        | БХД    | 22                                                       | 4      | 2               | 4         | 1        | 11      |
| 8        | БНД    | 78                                                       | 8      | 12              | 7         | 6        | 45      |
| 9        | НД     | 219                                                      | 6      | 15              | 124       | 7        | 67      |
| 10       | Бусад  | 9                                                        | 0      | 1               | 2         | 0        | 6       |
| Нийт дүн |        | 5564                                                     | 277    | 375             | 1922      | 109      | 2881    |

Нийт 5564 барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосноос 51.8% нь барилга, 34.5% нь цахилгаан, 6.7% нь засвар, тохижилт, 4.9% нь ИШС, 1.9% нь авто замын ажлын зөвшөөрөл байна.

Барилгын ажлын зөвшөөрлийг зориулалтаар нь ангилбал 1215 буюу 42.2%-ийг орон сууцны барилга эзэлж байна.

**Хүснэгт 11. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний зориулалт**


| № | Огноо | Барилга | Үүнээс           |          |          |         |           |       |
|---|-------|---------|------------------|----------|----------|---------|-----------|-------|
|   |       |         | Үйлчилгээ, оффис | Сургууль | Цэцэрлэг | Эмнэлэг | Орон сууц | Бусад |
| 1 | 2013  | 368     | 138              | 18       | 4        | 11      | 189       | 8     |
| 2 | 2014  | 296     | 79               | 12       | 21       | 4       | 180       |       |
| 3 | 2015  | 263     | 100              | 14       | 22       | 4       | 114       | 9     |
| 4 | 2016  | 164     | 60               | 13       | 7        | 6       | 57        | 21    |
| 5 | 2017  | 244     | 79               | 11       | 12       | 6       | 81        | 55    |
| 6 | 2018  | 393     | 103              | 42       | 24       | 13      | 135       | 76    |
| 7 | 2019  | 376     | 100              | 33       | 35       | 12      | 126       | 70    |
| 8 | 2020  | 445     | 116              | 28       | 36       | 15      | 207       | 43    |

| НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО, ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН |       |      |     |     |     |    |      |     |
|-------------------------------------------------------------------|-------|------|-----|-----|-----|----|------|-----|
| 9                                                                 | 2021  | 326  | 78  | 17  | 14  | 10 | 126  | 81  |
| 10                                                                | Бусад | 6    | 0   | 0   | 0   | 0  | 0    | 6   |
| Нийт дүн                                                          |       | 2881 | 853 | 188 | 175 | 81 | 1215 | 369 |

НЗД нь БТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1.6<sup>21</sup>-д заасан барилгын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийг хүлээдэг бөгөөд хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.23-т заасан “Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно” гэж заасны дагуу 16-аас дээш давхрын барилгын ажлын зөвшөөрлийг БХБЯ олгохоор заасан.

Гэтэл НЗД-ын захирамжаар байгуулагдсан мэргэжлийн зөвлөл нь 2013-2021 онуудад 51 барилгад 16-аас дээш давхрын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгожээ.


**График 12. 2013-2021 онд 16 давхраас дээш зөвшөөрөл олгосон мэдээлэл**



Аудитаар нийслэлийн ХУД-т баригдсан барилга байгууламжийг Нисэх-Яармаг орчмын орон сууцны ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэхийг зургаар харуулбал дараах байдалтай байна.

**Дүрслэл 8. 2020 онд олгогдсон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ**

2020 ОНД ОЛГОГДСОН БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



/Эх сурвалж: ХБХГ/


2020 оны зураглалаас харвал газар барилгажилтын мэргэжлийн зөвлөл нь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний газар ашиглалтын бүсчлэл харгалзахгүй орон сууцны барилгын ажлын зөвшөөрлийг олгосон байна. Энэ нь тус зөвлөл МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд Нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлого, НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон НИТХ, НЗД-аас хот байгуулалт, төлөвлөлт болон газрын харилцааны талаар баримтлах бодлого шийдвэрийг зөрчиж үндсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэхээр байна.

<sup>21</sup> 35.1.6.Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

Мөн Нийслэлд олгосон 2881 барилгын ажлын зөвшөөрлийг газрын зориулалтаар нь авч үзвэл дараах байдалтай байна.

Нийслэлд 2013-2021 онд олгосон 5564 барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 51.7% нь барилга, барилгын 42.2% нь орон сууц, 29.6% нь үйлчилгээ, оффис, 6.5% нь сургууль, 6% нь цэцэрлэг, 2.8% нь эмнэлэг, 12.9% нь бусад зориулалтын барилга байна.

**График 13. Барилгын зөвшөөрлийн эзлэх хувийг зориулалтаар харуулбал**



Дүрслэлээс харвал сүүлийн 10-аад жилд баригдсан барилгын 71.6% нь үйлчилгээ, оффис, орон сууцны барилгын зөвшөөрлийн гэрчилгээ олгож түүний дагуу 100% барилга баригдсан байна. Энэ нь түгжрэл үүсгэх суурь шалтгаан болжээ. Хэт их төлөвлөлтгүй барилга, орон сууц бариснаас түүнд чиглэсэн авто

зам, сургууль, цэцэрлэг, газар чөлөөлөлт, нийтийн тээвэр, ИШС-ний асуудал үүсч түүнд түгжрэлийн асуудлыг хандуулжээ.

Цаашид замын хөдөлгөөний түгжрэлийг асуудлыг шийдвэрлэхдээ Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэх, газар олголт барилгажилтыг асуудлыг тодорхой хэмжээнд хязгаарлах талаар эрх зүйн орчныг бий болгох, газар чөлөөлөлтийн асуудлыг онцгой анхаарах шаардлага үүссэн байна.

**Дүгнэлт:** Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь салбар хоорондын уялдаагүй байдлаас шалтгаалж үр дүнгүй байна.


## **2.2 Нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулахад батлагдсан хөрөнгө үр дүнтэй байна уу?**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулах, ачааллыг бууруулах чиглэлээр батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-үүд бодлогын баримт бичгийн зорилтод түвшинд хүрээгүй, ТАХ-ээг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжилт удааширсан, Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим ТАХ нь тооцоо судалгаан дээр бүрэн төлөвлөгдөж эхлээгүй, санхүүжилт удааширснаас ТАХ-ний үр дүнг бууруулах, зээлийн хөрөнгийг буцаан татуулах, үр ашиггүй зарцуулах үндэслэл болж байна.

### **2.2.1 Төлөвлөлт оновчтой байна уу?**

2012-2021 онд авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр улсын төсвийн хөрөнгөөр 413,601.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 339 ТАХ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 522,876.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 763 ТАХ, НЗСХ-өөр 306,883.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1810 ТАХ, нийт 1,232,262.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2912 ТАХ баталжээ.

**График 14. ТАХ-ний төсөвт өртгийг зориулалт 2012-2021 он (хувиар)**



Аудитаар дараах төсвийн төлөвлөлт нь бодлогын баримт бичигт нийцэж буй эсэхийг авч үзэхэд:

### **Сургууль цэцэрлэг:**

2012-2021 онд улс, нийслэлийн төсвөөр 445,549.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 450 ТАХ-г сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх, засварлахаар төлөвлөжээ.

**Хүснэгт 12. 2012-2021 онд төлөвлөсөн сургууль, цэцэрлэгийн тоо**

| №    | Дүүрэг | Сургууль   |             |                      | Сургууль, цэцэрлэгийн цогцолбор |                      |            | Цэцэрлэг    |                      |  |
|------|--------|------------|-------------|----------------------|---------------------------------|----------------------|------------|-------------|----------------------|--|
|      |        | Төлөвлөсөн | Суудлын тоо | Хүчин чадлын хэтрэлт | Төлөвлөсөн                      | Хүчин чадлын хэтрэлт | Төлөвлөсөн | Суудлын тоо | Хүчин чадлын хэтрэлт |  |
| 1    | БГД    | 8          | 5340        | 40%                  | 2                               | 1140/400             | 11         | 2080        | 35%                  |  |
| 2    | БЗД    | 8          | 5660        | 100%                 | 3                               | 540/360              | 17         | 2970        | 90%                  |  |
| 3    | СБД    | 8          | 4240        | 18%                  | 3                               | 540/360              | 4          | 615         | 70%                  |  |
| 4    | СХД    | 7          | 3720        | 100%                 | 3                               | 540/360              | 31         | 5080        | 30%                  |  |
| 5    | ХУД    | 4          | 2480        | 20%                  | 3                               | 540/360              | 12         | 2410        | 70%                  |  |
| 6    | ЧД     | 3          | 1410        | 70%                  | 6                               | 1020/720             | 17         | 3025        | 90%                  |  |
| 7    | БНД    | -          | -           | -                    | -                               | -                    | 2          | 340         | 20%                  |  |
| 8    | НД     | 1          | 960         | 30%                  | -                               | -                    | 1          | 75          | 40%                  |  |
| Нийт |        | 39         | 23810       | -                    | 20                              | 4320/2560            | 95         | 16595       | -                    |  |

Хүснэгтээс харвал "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-н 1-р ботийн 2.1.3-т цэцэрлэгийн хүчин чадал хэтэрсэн байдлыг хувиар илэрхийлсэн бөгөөд зарим дүүрэгт сургууль, цэцэрлэгийн хүчин чадал хэтэрсэн байдалд үндэслэн төлөвлөөгүй байна. Тухайлбал:

➤ Төвийн 6 дүүргээс сургуулийн хүчин чадал хэтэрсэн байдлаас хамгийн бага үзүүлэлттэй буюу 18% СБД-т 8 сургууль төлөвлөсөн бол 20%-ийн хэтрэлттэй байсан ХУД-т 4 сургууль, 70%-ийн хэтрэлттэй байсан ЧД-т 3 сургууль төлөвлөжээ.

➤ Цэцэрлэгийн хүчин чадал хэтэрсэн байдлаар хамгийн бага хувьтай байсан СХД-т 31 цэцэрлэг төлөвлөсөн бол 70 хувийн хэтрэлттэй байсан ХУД-т 12 цэцэрлэг, СБД-т 4 цэцэрлэг барих болон өргөтгөхөөр төлөвлөжээ.

"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-н баримт бичгийн 3.6.1-д 2020 онд 113,052 суудал бүхий сургуулийг шинээр барихаар төлөвлөсөн бөгөөд сургууль барих, өргөтгөхөөр батлагдсан 32 ТАХ, 20 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын ТАХ нь 27,830 суудлаар нэмэгдүүлэхээр төсөвт тусгагдсан, 85,219 ортой цэцэрлэг шинээр барихаар төлөвлөсөн ч цэцэрлэг барих, өргөтгөх 89 ТАХ, 20 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын ТАХ нь 19,155 ороор нэмэгдүүлэхээр төсөвт тусгаж баталсан нь зорилтдоо хүрээгүй байна.

### **Нийтийн тээврийн хүртээмж нэмэгдүүлэх:**

Нийтийн тээврийн парк шинэчлэлтэд 71,763.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80 ТАХ хэрэгжүүлэхээр баталснаас 52,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ээр 196 автобус худалдан авахаар төлөвлөжээ. "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг

хандлага” баримт бичигт 2030 он гэхэд 2000 автобус, троллейбус үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн ч 2021 оны байдлаар нийслэлд 1253 автобус үйлчилгээ үзүүлж байгаа нь төлөвлөсөн тооноос 37.3%-аар бага байна.

Мөн дээрх баримт бичгийн 3.3.2-т тусгай замын автобусны (BRT) зам барьж, байгуулна гэж тусгажээ. АХБ-ны санхүүжилтээр “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн нэгдүгээр үе шатыг хэрэгжүүлж нийслэлийн 2018 оны төсөвт 159.6 сая төгрөг, 2019 оны төсөвт 1,000.0 сая төгрөг, нийт 1,159.6 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд УБ хотын хариуцах хөрөнгө байхаар баталсан байна.

### **Авто зам, замын байгууламж:**

2012-2021 оны хугацаанд замын ажилд 548,186.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2043 ТАХ-г тусгажээ.

#### ***Хүснэгт 13. 2012-2021 оны хугацаанд Замын салбарт гаргасан ТАХ-ний мэдээлэл***

| № | Зориулалт              | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг<br>/сая.төг/ |
|---|------------------------|-------------|---------------------------|
| 1 | Авто зам, гүүр барих   | 124         | 309,149.3                 |
| 2 | Авто замын зураг төсөл | 135         | 17,341.2                  |
| 3 | Зам засвар, арчлалт    | 1619        | 189,952.3                 |
| 4 | Явган болон дугуйн зам | 165         | 31,744.0                  |
|   | <b>Нийт</b>            | <b>2043</b> | <b>548,186.8</b>          |

Шинээр авто зам барих, өргөтгөн шинэчлэх ажилд 309,149.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 124 төсөл арга хэмжээг төлөвлөснөөс 6 ТАХ нь хорооллын дундах авто замын ажил байна. Тухайн 6 ТАХ-ний 2-г нь нийслэлийн төсвөөс, 4-г нь Улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгажээ. 2020 оны Улсын төсвөөр хорооллын дундах авто зам барихаар 3,708.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ нь бодлогын баримт бичигт тусгагдаагүй:

- Ханын материал орчмын орон сууцын хорооллын доторх хатуу хучилттай авто зам, 0.93 км /Улаанбаатар, СХД, 6 дугаар хороо/
- Хорооллын доторх авто зам /Улаанбаатар, ЧД, 15 дугаар хороо/
- Хорооллын доторх чулуун болон асфалтан зам /Улаанбаатар, ЧД, 12 дугаар хороо/
- Хорооллын дундах авто зам /Улаанбаатар, БГД, 9, 21 дүгээр хороо/

Нийслэлийн замын сангийн төсөвт 2012-2021 оны хугацаанд авто зам барилгын 92,316.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 66 ТАХ-г тусгажээ. Энэ нь Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 3-р зүйлийн 3.5.1-т “төсвийн 90-ээс багагүй хувийг АЗТХ-ийн 24.3<sup>22</sup>, 24.4<sup>23</sup>-т тус тус заасан үйл ажиллагаанд”, тус журмын 3.5.2-т “төсвийн 10 хүртэлх хувийг АЗТХ-ийн 24.5<sup>24</sup>-д заасан үйл ажиллагаанд” заасныг зөрчиж байна.

### **Түгжрэл бууруулах чиглэлээр батлагдсан 2022 оны төсвийн төлөвлөлт:**

НИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 180 дугаар тогтоолоор НУБХАЗТБНТХН ОНӨТҮГ байгуулж, нийслэлийн авто замын хөдөлгөөний түгжрэлд зарцуулах төсөл арга хэмжээний төсвийг НИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор 888,939.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 багц ажлыг хэрэгжүүлэхээр 265 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

<sup>22</sup> Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

<sup>23</sup> Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.

<sup>24</sup> Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

**График 15. Түгжрэл бууруулах чиглэлээр батлагдсан төсвийн ангилал**



Шинээр барих гол болон туслах гудамж зам барих ажилд нийт төсвийн 26 хувь буюу 228,114.2 сая төгрөг, газар чөлөөлөлтөд 13% буюу 110.0 сая төгрөг, нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, автобусны зогсоол шинээр барих ажилд 9% буюу 83,260.4 сая төгрөг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ТАХ-нд 28% буюу 249,900.2 сая төгрөгийг баталжээ. Аудитаар нийт төсвийн 76%-ийн ТАХ-ний төлөвлөлтийг хамруулав.

#### **Авто зам, замын байгууламж барих:**

Шинээр гол болон туслах зам барихаар 228,144.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ-г тусгажээ. Шинээр 4 байршилд 10.17 км урт авто зам, 930.7 метр урт гүүрэн байгууламжийн гол гудамж зам, 9 байршилд 12.32 км урт, 30 метр урт гүүрэн байгууламжийн туслах гудамж замыг барихаар төлөвлөжээ. Тухайн замуудыг ХУД-т 6, СХД-т 3, БГД-т 2, БЗД-т 2 зам барихаар төлөвлөсөн бол СБД болон ЧД-т шинээр зам барихаар төлөвлөөгүй байна.

Төлөвлөгдсөн 4 гол гудамжны Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, замын байгууламж, Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, гүүрний барилгын ажил нь “Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандалга” бодлогын баримт бичигт хотын дундуур гарсан параллель 6, босоо 9 гол гудамж зам байхаар төлөвлөгдсөнтэй уялдсан байна.

#### **Газар чөлөөлөлт:**

Авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор хийгдэх ТАХ-ний 2022 оны газар чөлөөлөлтийг 110,801.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 74,819.6 сая төгрөгийн санхүүжих дүнгээр тусгажээ. Тухайн санхүүжилтээр шинээр баригдах гол замын нөлөөлөлд өртсөн 459 нэгж талбар, туслах замын нөлөөлөлд өртсөн 131, цэцэрлэг, сургууль барих ажлын нөлөөлөлд өртсөн 127 нэгж талбар, хөгжлийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн 236 нэгж талбар, нийт 953 нэгж талбарыг чөлөөлөхөөр төлөвлөжээ.

**Хүснэгт 14. 2022 оны Нийслэлийн төсвийн авто замын түгжрэл бууруулах төсөл арга хэмжээний газар чөлөөлөлтийн мэдээлэл (тоогоор)**

| № | Зориулалт                       | Чөлөөлөхөөр төлөвлөсөн нэгж талбарын тоо | Нөлөөлөлд өртсөн нэгж талбар | Чөлөөлсөн нэгж талбар | Чөлөөлөөгүй нэгж талбар |
|---|---------------------------------|------------------------------------------|------------------------------|-----------------------|-------------------------|
| 1 | Шинээр барих гол зам            | 459                                      | 452                          | 323                   | 129                     |
| 2 | Шинээр барих туслах зам         | 131                                      | 127                          | 46                    | 81                      |
| 3 | Шинээр барих сургууль, цэцэрлэг | 127                                      | 178                          | 134                   | 44                      |

|   |                          |            |             |            |            |
|---|--------------------------|------------|-------------|------------|------------|
| 4 | Он дамжсан зам,<br>замын | 26         | 5           | 21         |            |
| 5 | Хөгжлийн төслүүд         | 236        | 236         | 9          | 227        |
|   | <b>Нийт</b>              | <b>953</b> | <b>1019</b> | <b>517</b> | <b>502</b> |

Замын хөдөлгөөний түгжрэл бууруулах чиглэлээр 2022 онд 5 чиглэлээр хэрэгжүүлэх 29 ТАХ-ний хүрээнд 953 нөлөөлөлд өртсөн нэгж талбарыг чөлөөлөхөөр баталснаас 517 нэгж талбарыг чөлөөлж, 502 нэгж талбарыг чөлөөлөөгүй байна. Үүнээс шалтгаалж 2022 оноос хэрэгжиж эхлэх 18 ТАХ-г эхлүүлэх боломжгүйд хүрч нийт ажлын 62% нь хүлээгдэж байна.

Мөн газар чөлөөлөлтийн хүрээнд 953 нэгж талбарыг чөлөөлөхөөр төлөвлөсөн ч НЗД-ийн захирамжаар 2021-2022 оноос он дамжин хэрэгжих байгаа авто зам барих ажлын газар эзэмшигчтэй тохиролцоонд хүрээгүйгээс чөлөөлөгдөөгүй үлдсэн 26 нэгж талбарын нөхөн олговорт 1,780.6 сая төгрөгийг түгжрэл бууруулах төсвийн хөрөнгөөс олгожээ.

### **Цэцэрлэг, сургууль:**

Авто замын авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээний жагсаалтад цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 169,991.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 205 ТАХ, сургуулийн хүртээмжийг нэмэх зорилгоор 80,201.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 ТАХ тусгагджээ.

#### ***Хүснэгт 15. Сургууль, цэцэрлэгийн байршил***

| № | Дүүрэг      | Цэцэрлэг |                                 |                                     |                    |                                      | Сургууль |          | Нийт      |
|---|-------------|----------|---------------------------------|-------------------------------------|--------------------|--------------------------------------|----------|----------|-----------|
|   |             | Шилжих   | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга | Цэцэрлэгийн зорилгоор худалдаж авах | Бие даасан барилга | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор | Шилжих   | Шинэ     |           |
| 1 | БГД         | 1        | 3                               | 2                                   | 1                  | -                                    | -        | -        | 7         |
| 2 | БЗД         | 1        | 3                               | 5                                   | 7                  | -                                    | 1        | 1        | 18        |
| 3 | ЧД          | -        | -                               | -                                   | -                  | -                                    | 1        | -        | 1         |
| 4 | СХД         | -        | -                               | 2                                   | 5                  | 4                                    | -        | 1        | 12        |
| 5 | СБД         | -        | 1                               | -                                   | -                  | -                                    | -        | -        | 1         |
| 6 | ХУД         | -        | -                               | 4                                   | 4                  | 5                                    | -        | 4        | 17        |
| 7 | БНД         | 1        | -                               | -                                   | -                  | -                                    | -        | -        | 1         |
|   | <b>Нийт</b> | <b>3</b> | <b>7</b>                        | <b>13</b>                           | <b>17</b>          | <b>9</b>                             | <b>2</b> | <b>6</b> | <b>57</b> |

Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд төлөвлөсөн ТАХ-ний дийлэнх хувь нь ХУД, СХД, БЗД-т байршиж байгаа нь төвлөрлийг сааруулахад чиглэсэн байна.

Цэцэрлэгийн барилга болон бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга барихаар 96,233.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ төлөвлөснөөс 17,124.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 ТАХ нь газаргүй буюу байршил тодорхой бус, 14,600.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 ТАХ-ний газар нь шүүхийн маргаантай байгаа нь Төвийн тухай хуулийн 29<sup>1</sup>-р зүйлийн 29<sup>1</sup>.2.1-т “*тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх*” гэж заасныг зөрчсөн байна.

### **Нийтийн тээврийн хүртээмж нэмэгдүүлэх:**

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, автобусны зогсоол шинээр барих ажилд 83,260.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г төлөвлөжээ. Үүнээс нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх ажилд 6,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 36 байршилд дундын зогсоол, 6 байршилд эцсийн зогсоол хийхээр төлөвлөжээ. Автобусны парк шинэчлэхээр 77,260.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 ширхэг цахилгаан хөдөлгүүртэй автобус, 441 ширхэг дизель хөдөлгүүртэй автобус нийт 591 ширхэг автобус шинээр худалдан авахаар төлөвлөсөн байна.

**Дүгнэлт:** Замын хөдөлгөөн зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээрх арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн зорилтот түвшинд хүрээгүй буюу оновчгүй байдлаар төлөвлөжээ.

## 2.2.2 Улс, орон нутгийн төсвөөс нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулахад зарцуулсан хөрөнгө үр дүнтэй байна уу?

Нийслэлд 2012-2021 онд замын хөдөлгөөнийг зохицуулах, ачааллыг бууруулах чиглэлээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1,232,262.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2912 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас НЗХГ, НХОГ, ННТГ-ууд 1,062,943.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1782 ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Тухайлбал:

**ННТГ:** 2012-2021 онд нийтийн тээврийн хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор парк шинэчлэл хийх, сургуулийн хүүхдийн автобусыг шинээр нэвтрүүлэх зэрэг төслийн хүрээнд 60,370.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ буюу 207 их оврийн, цахилгаан, угсраа зэрэг автобусыг нийлүүлэхээр гэрээ байгуулан ажилласан бол 2021 онд 1,180.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 судалгаа, ТЭЗҮ-ний ажлуудын хэрэгжилтийг хангуулан ажиллажээ.

**График 16. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн зориулалт болон хүчин чадлын үзүүлэлт**



“Хүүхдийн сургуулийн автобусны төсөл”-ийн хүрээнд авч хэрэгжүүлсэн 75 автобуснаас 25 нь нийлүүлэгдсэн буюу 33.3%-н хэрэгжилттэй гэрээ сунгасан байдалтай байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийтийн тээвэрт явж буй 1200 гаруй төр, хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл байгаагаас дундаж насжилт 9,5 жил, 2021-2024 онуудад насжилт дуусах автобусны тоо 800 гаран байна. Үүнээс харахад 2012 оноос хойш парк шинэчлэлийн эргэц удаашралтай, тооцоо судалгаа оройтож хийгдсэн, төсөвт мөнгө хангалттай хэмжээнд тусгагдаагүй байдалтай байна.

**НЗХГ:** 2012-2021 онуудад 526,122.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1052 ТАХ-ны гэрээний хэрэгжилтийг хангуулахаар гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажилласнаас 293,257.1 сая төгрөг буюу 55.7%-ийг НЗС-аас, 164,915.1 сая төгрөг буюу 31.3%-ийг НТХО-аар, 49,577.1 сая төгрөг буюу 9.5%-ийг УТХО-аар, 18,373.1 сая төгрөг буюу 3.5%-ийг бусад эх үүсвэрээс тус тус санхүүжигджээ.

**Хүснэгт 16. Улс, нийслэлийн хөрөнгөөр 2012-2021 онуудад гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр ажилласан ТАХ-үүд**

/сая.төг/

|   |      | Улс, нийслэлийн хөрөнгө оруулалт |                    |                   |                    |             |                    |                        |                    |       |                    |
|---|------|----------------------------------|--------------------|-------------------|--------------------|-------------|--------------------|------------------------|--------------------|-------|--------------------|
| № | Он   | Авто зам, гүүр                   |                    | Өргөтгөл шинэчлэл |                    | Зураг төсөв |                    | Явган зам, гүүрэн гарц |                    | Бусад |                    |
|   |      | тоо                              | гэрээний үнийн дүн | тоо               | гэрээний үнийн дүн | тоо         | гэрээний үнийн дүн | тоо                    | гэрээний үнийн дүн | тоо   | гэрээний үнийн дүн |
| 1 | 2012 | 4                                | 4,490.1            | 5                 | 12,577.7           | 8           | 598.2              | 1                      | 2,101.6            | 3     | 851.4              |
| 2 | 2013 | 10                               | 25,194.2           | 2                 | 1,464.7            | 0           | -                  | 0                      | -                  | 3     | 1,511.5            |
| 3 | 2014 | 5                                | 4,151.8            | 3                 | 435.2              | 21          | 3,610.1            | 0                      | -                  | 4     | 4,120.2            |
| 4 | 2015 | 1                                | 6,123.6            | 2                 | 5,106.8            | 8           | 1,456.6            | 1                      | 766.3              | 4     | 18,914.4           |
| 5 | 2016 | 3                                | 6,158.8            | 1                 | 249.0              | 0           | -                  | 0                      | -                  | 2     | 1,693.4            |

| НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО, ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН |      |    |           |    |          |     |          |    |          |          |
|-------------------------------------------------------------------|------|----|-----------|----|----------|-----|----------|----|----------|----------|
| 6                                                                 | 2017 | 1  | 6,353.4   | 3  | 2,747.8  | 6   | 1,060.9  | 7  | 894.9    | 12.0     |
| 7                                                                 | 2018 | 8  | 25,665.5  | 9  | 6,984.3  | 0   | -        | 0  | -        | -        |
| 8                                                                 | 2019 | 1  | 664.8     | 0  | -        | 0   | -        | 12 | 2,189.7  | 15,544.3 |
| 9                                                                 | 2020 | 23 | 35,476.2  | 10 | 13,154.0 | 8   | 458.4    | 1  | 9,796.4  | 56.0     |
| 10                                                                | 2021 | 0  | -         | 2  | 497.0    | 86  | 5,361.0  | 0  | -        | -        |
| Нийт                                                              |      | 56 | 114,278.4 | 37 | 43,216.5 | 137 | 12,545.2 | 22 | 15,748.9 | 28,703.2 |

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт ТАХ-ны 38.4% буюу 19,013.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй авто зам, замын өргөтгөл, шинэчлэлийн 13 ТАХ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт ТАХ-ны 3.2% буюу 5,288.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй авто зав, замын өргөтгөл, шинэчлэл, засварын 3 ТАХ-үүд нь 2-3 жил он дамжин 2-5 удаа гэрээ сунгагдаж байгаа нь замын ачааллыг бууруулах зорилт, арга хэмжээнд сөргөөр нөлөөлж ТАХ-ны үр дүнг бууруулж байна.

**Хүснэгт 17. НЗС болон бусад эх үүсвэрээс 2012-2021 онуудад гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр ажилласан ТАХ-үүд**

| №    | Он   | НЗС         |                            | ОНХС        |                            | БУСАД       |                            |
|------|------|-------------|----------------------------|-------------|----------------------------|-------------|----------------------------|
|      |      | ТАХ-ний тоо | ТАХ-ний гэрээний үнийн дүн | ТАХ-ний тоо | ТАХ-ний гэрээний үнийн дүн | ТАХ-ний тоо | ТАХ-ний гэрээний үнийн дүн |
| 1    | 2012 | 49          | 14,482.4                   | -           | -                          | -           | -                          |
| 2    | 2013 | 98          | 20,779.3                   | -           | -                          | 6           | 8,254.7                    |
| 3    | 2014 | 57          | 28,690.5                   | -           | -                          | 13          | 766.0                      |
| 4    | 2015 | 32          | 14,761.7                   | -           | -                          | 7           | 755.3                      |
| 5    | 2016 | 48          | 13,164.8                   | -           | -                          | -           | -                          |
| 6    | 2017 | 134         | 34,272.7                   | -           | -                          | 2           | 1,054.0                    |
| 7    | 2018 | 28          | 14,009.3                   | -           | -                          | -           | -                          |
| 8    | 2019 | 57          | 31,161.1                   | -           | -                          | -           | -                          |
| 9    | 2020 | 80          | 95,285.6                   | 39          | 3,101.1                    | 3           | 803.5                      |
| 10   | 2021 | 85          | 26,649.8                   | 28          | 3,638.5                    | -           | -                          |
| Нийт |      | 668         | 293,257.1                  | 67          | 6,739.6                    | 31          | 11,633.5                   |

2012-2021 онд НЗС болон бусад эх үүсвэрээс 311,630.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 766 ТАХ-г хэрэгжүүлэхээр ажилласнаас 11% буюу 34,399.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй хорооллын дундах авто зам, замын засвар, шинэчлэлийн 21 ТАХ-үүд 2-3 жил он дамжин 2-5 удаа гэрээ сунгагдсан байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр замын салбарт оруулсан хөрөнгө оруулалтын ТАХ-үүд удааширч он дамжин хэрэгжиж байгаа нь ажлыг төлөвлөлтгүй эхлүүлсэн, тухайн онд санхүүжигдэх хөрөнгө бүрэн тусгагддаггүй, газар чөлөөлөлтийн байдал удаашралтай, мэргэжлийн байгууллагын саналыг тусгаагүй, ковид-19 цар тахал зэрэг шалтгаанаар гэрээ сунгагдсан мөн цуцлагдсан байна. Энэ нь Замын тухай хуулийн 12.1.8<sup>25</sup>, 20.2<sup>26</sup> дахь заалтууд зөрчигдөж ТАХ-г төлөвлөж, батлуулсан чиг үүргийн хүрээнд ажил эхлүүлсэн зэрэг зөрчилтэй байна.

**НХОГ:** 2012-2021 онуудад 475,271.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 715 ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг хангуулахаар гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажилласнаас 328,832.7 сая төгрөг буюу 69.2%-ийг УТХО-аар, 146,438.6 сая төгрөг буюу 30.8%-ийг НТХО-р тус тус санхүүжигджээ.

**Хүснэгт 18. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2012-2021 онуудад санхүүжигдэн бүрэн ашиглалтад орсон ТАХ-үүд**

| Улс, нийслэлийн төсвөөр санхүүжигдэж бүрэн ашиглалтад орсон |    |                              |                    |                               |                    |                                 |                    |                         |                    | /сая.төг/                          |                    |
|-------------------------------------------------------------|----|------------------------------|--------------------|-------------------------------|--------------------|---------------------------------|--------------------|-------------------------|--------------------|------------------------------------|--------------------|
| №                                                           | Он | Сургуулийн барилга, өргөтгөл |                    | Цэцэрлэгийн барилга, өргөтгөл |                    | Сургууль, цэцэрлэгийн цогцолбор |                    | Их засвар, шугам сүлжээ |                    | Тохижилт, бусад барилга байгууламж |                    |
|                                                             |    | тоо                          | гэрээний үнийн дүн | тоо                           | гэрээний үнийн дүн | тоо                             | гэрээний үнийн дүн | тоо                     | гэрээний үнийн дүн | тоо                                | гэрээний үнийн дүн |
|                                                             |    |                              |                    |                               |                    |                                 |                    |                         |                    |                                    |                    |


<sup>25</sup> 12.1.9.аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч тусгах.

<sup>26</sup> 20.2.Захиалагч нь авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, авто замын барилгын ажил явуулах талбайг чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн байна.

|      |      |    |          |    |           |    |          |     |          | үнийн<br>дүн |          |
|------|------|----|----------|----|-----------|----|----------|-----|----------|--------------|----------|
| 1    | 2012 | 0  | -        | 3  | 1,215.5   | 0  | -        | 109 | 5,530.6  | 18           | 1,080.0  |
| 2    | 2013 | 0  | -        | 2  | 887.2     | 0  | -        | 85  | 5,749.3  | 4            | 777.9    |
| 3    | 2014 | 2  | 4,737.5  | 2  | 3,564.7   | 1  | 2,200.0  | 50  | 5,208.6  | 2            | 2,289.0  |
| 4    | 2015 | 2  | 3,548.2  | 6  | 7,156.1   | 6  | 12,904.4 | 44  | 8,226.3  | 4            | 3,056.2  |
| 5    | 2016 | 3  | 4,977.8  | 12 | 16,812.6  | 7  | 15,106.6 | 9   | 4,083.0  | 7            | 4,126.7  |
| 6    | 2017 | 4  | 39,723.9 | 6  | 9,615.8   | 0  | -        | 40  | 2,884.6  | 5            | 191.4    |
| 7    | 2018 | 1  | 1,277.1  | 7  | 11,346.4  | 0  | -        | 38  | 4,747.1  | 2            | 251.1    |
| 8    | 2019 | 7  | 15,490.8 | 10 | 13,648.7  | 0  | -        | 28  | 4,040.6  | 14           | 6,921.5  |
| 9    | 2020 | 3  | 11,782.9 | 12 | 20,253.1  | 1  | 15,000.0 | 36  | 5,336.0  | 12           | 6,719.1  |
| 10   | 2021 | 3  | 14,066.1 | 13 | 25,921.5  | 1  | 3,371.1  | 30  | 4,007.1  | 7            | 3,219.5  |
| Нийт |      | 25 | 95,604.3 | 73 | 110,421.6 | 16 | 48,582.1 | 469 | 49,813.2 | 75           | 28,632.5 |

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт ТАХ-ний 38.0% буюу 110,674.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй сургууль, цэцэрлэгийн барилгын 27 ТАХ, 14,284.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй их засвар, тохижилт, инженерийн шугам сүлжээний 10 ТАХ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт ТАХ-ний 11.8% буюу 13,190.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй сургуулийн барилга, өргөтгөлийн 2 ТАХ, 4,067.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй их засвар, тохижилт, инженерийн шугам сүлжээний 18 ТАХ-үүд нь 2-3 жил он дамжин 2-8 удаа гэрээ сунгагдаж хэрэгжилт удааширсан нь сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, замын ачааллыг бууруулах зорилтод сөргөөр нөлөөлж хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

**График 17. Сургууль цэцэрлэгийн барилгын хэрэгжилтийн тоон мэдээ**



Нийт УТХО-аар санхүүжигдэн ашиглалтад орох 66 сургууль, цэцэрлэгийн барилгын 40.9% буюу 27 нь, НТХО-аар санхүүжигдэн ашиглалтад орох 48 сургууль, цэцэрлэгийн барилгын 4.2% буюу 2 нь зураг төсөвгүй, газар чөлөөлөлт хийгдээгүй, тухайн онд санхүүжигдэх хөрөнгө бүрэн тусгагдаагүй зэргээс шалтгаалан удааширсан байна.

Үүнээс үүдэн 9760 суудалтай 14 сургуулийн барилга, өргөтгөл, 2230 ортой 12 цэцэрлэгийн барилга, өргөтгөл, 780 суудалтай 3 сургууль, цэцэрлэгийн цогцолбор одоог хүртэл ашиглалтад ороогүй байгаа нь сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтдоо хүрэхгүй зэргээр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

**Дүгнэлт:** Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийслэлийн замын хөдөлгөөнийг зохицуулах, ачааллыг бууруулахад зарцуулсан хөрөнгө оруулалтын ТАХ-үүд нь төлөвлөлт хангалтгүй, газар чөлөөлөлт болон тухай жилд санхүүжигдэх мөнгөн дүн бүрэн тусгагдаагүй, зэрэг шалтгаанаар удааширсан, энэ нь ТАХ-ний үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

### 2.2.3 Гадаадын зээл, хандив, бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний үр дүнтэй байна уу?

Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр болон өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 53 ТАХ-нээс гэрээний үнийн дүнгээр 3,346.0 сая ам.долларын 21 ТАХ, 35.4 сая еврогийн 1 ТАХ, 155,107.6 сая төгрөгийн 31 ТАХ тус тус санхүүжигдэн хэрэгжиж байна.

**Хүснэгт 19. Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-ний олгогдсон нийт санхүүжилт**

| № | Утга                      | Санхүүжигдэх валютын төрөл |           |       |
|---|---------------------------|----------------------------|-----------|-------|
|   |                           | Төгрөг                     | Ам.доллар | Евро  |
| 1 | Гэрээний үнийн дүн        | 155,107.60                 | 3,346.00  | 35.40 |
| 2 | Олгогдсон санхүүжилт      | 104,266.50                 | 176.40    | 6.70  |
| 3 | Санхүүжигдсэн ТАХ-ний тоо | 31                         | 21        | 1     |

Үүнээс 38 ТАХ бүрэн хэрэгжиж дуусан, 88,803.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 15 ТАХ нь 3%-с 90%-н гүйцэтгэлтэй хэрэгжилтийн шатандаа байна.

**Дүрслэл 9. БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-үүд**



БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр нийслэлийн 4 байршилд зам гүүрийн 130.6 сая ам.долларын төсөвт өртөгтэй 4 ТАХ-г 2016-2022 онуудад бүрэн хэрэгжүүлж дууссан байна.

- Замын Цагдаагийн газрын баруун өмнөх уулзварт барих гүүрэн гарц барих төсөл /Хэрэгжих хугацаа: 2016-2022; Гүйцэтгэгч: "Хятадын Төмөр замын 20-р товчоо групп корпорац" ХХК
- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20,9 км замын өргөтгөл, шинэчлэл /Хэрэгжих хугацаа: 2017-2022; Гүйцэтгэгч: "Синопхайдро корпорейшин лимитед" ХХК /
- Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл /Хэрэгжих хугацаа: 2016-2019; Гүйцэтгэгч: "Хятадын Төмөр замын 20-р товчоо групп корпорац" ХХК/
- "Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл"/Хэрэгжих хугацаа: 2018-2020; Гүйцэтгэгч: "Бээжин Юни-Констракшин Групп" ХХК/

**"Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төсөл:**

Энэхүү төсөл нь 3 үе шаттай 344.2 сая ам.долларын санхүүжилт бүхий гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулах, нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгох зорилго бүхий төсөл бөгөөд төслийн 1 дүгээр үе шатны хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төв, 2 дугаар үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төв, 3 дугаар үе шатны хүрээнд Шархад, Толгойт дэд төвүүдийг тус тус байгуулагдахаар АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2018-2023 онуудад хэрэгжүүлэхээр батлагджээ.

Гэвч 2022 оны байдлаар Монголын талын санхүүжилт удааширсан, Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэн, бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан гэрээний үнийн дүнд өөрчлөлт оруулах хүсэлтэй байгаа зэрэг шалтгаанаар зарим төсөл удааширсан зарим төсөл түр зогссон байдалтай байна.

Төслийн явц нь:

- Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалт 100%;
- Дамбадаржаа, дэнжийн 1000 олон нийтийн төвийн бүтээн байгуулалт 46%;
- Шархад, Толгойт олон нийтийн төвийн бүтээн байгуулалт 11%-ийн явцтай.

Эхний төсөл удааширснаар дараа дараагийн хөрөнгө оруулалтын хугацаа хойшилж 2023 он гэхэд бүрэн хэрэгжиж дуусан байх 55 мянган ажлын байр, төрийн үйлчилгээний 22 сургууль, 55 цэцэрлэг, ногоон байгууламж, төр захиргааны барилга

байгууламж зэрэг олон бүтээн байгуулалтын ажлууд хойшлогдож хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

**“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл:**

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкт хамтран нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобусны тээврийг нэвтрүүлэн нийтийн тээврийн салбарт шинэчлэлт, парк шинэчлэлт, авто зам шинэчлэлт хийх, зам тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх замаар түгжрэлийг бууруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилготой 2017 онд төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан.

***Дүрслэл 10. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 буюу BRT төслийн төлөвлөлтийн зураг***




Зөвлөхийн сонгон шалгаруулалт 3 жил дараалан зарлагдсан. Зөвлөхийн гэрээний төслийг АХБ-нд хүргүүлсэн боловч шалгарсан байгууллага нь бүрэн шаардлага хангасан материал ирүүлээгүй үндэслэлээр цуцлагдаж АХБ-аас зээлийн хугацааг 3 удаа сунгасан ахин сунгах боломжгүйг зарласнаар санхүүжилт зогсож 2020 оны 2 дугаар сард төсөл татан буугдсан.

Төслийн хүрээнд 2017 онд 2,829.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн зээлийг АХБ-с авч үйл ажиллагааны зардалд зарцуулсан бөгөөд 2020 оны 2 дугаар сард зээлийн ашиглалтыг дуусгавар болгох НЗД-ын захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 9 дүгээр сард АХБ-тай тооцоо нийлж, үйл ажиллагаанд ашигласан зээлийн төлбөр нь 2021 оны жилийн эцсийн байдлаар төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд ашиглагдсан 4,651.0 сая төгрөгийн өр хуримтлагдсан бөгөөд энэ нь үндсэн төлбөр, хүүгийн өр байна. Хэрэгжүүлж эхлэхдээ тавьсан зорилтдоо хүрч үр ашгаа өгөөгүй, төсвийн мөнгийг тооцоо судалгаа, төлөвлөлтгүй эхлүүлж зээлийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан байна.

**“Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”:**

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, авто замын түгжрэлийг бууруулж, агаарын бохирдлыг багасгах, цагт 3,000 зорчигч, өдөрт 22,000 зорчигч тээвэрлэж, трассын дагуух автомашины хэрэглээг 21 хувь бууруулах зорилго бүхий кабины багтаамж 8-10 зорчигчтой, 18 км/цаг хурдтайгаар цагийн хуваарийн дагуу хүлээгдэл үүсгэхгүйгээр иргэдэд үйлчлэх агаарын дүүжин тээврийг төслийг 2020 оноос хэрэгжүүлэхээр баталжээ.

**Дүрслэл 11. “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”**



Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн эхний гэрээг 35.4 сая еврогоор 2020 оны 6 дугаар сард байгуулж 2020-2023 онд хэрэгжүүлэхээр төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, урьдчилгаа төлбөрт 6.7 сая еврог Францын ЗГ-с зээлж 2020 оны 9 сард Францын Пома ХХК-д шилжүүлсэн байна. Төслийн нэгж нь 2020-2021 онуудад нийт 468 сая төгрөгийн цалин, түрээс бусад үйл ажиллагааны зардал гарган ажиллажээ.

Төслийн нэгжийг 2021 оны 12 дугаар сард НИТХ-ын тэргүүлэгчдийн №191 тоот тогтоолоор татан буулгаж, НЗД-ын 2022 оны 6 дугаар сарын А/882 тоот захирамжаар “Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” НӨТҮГ-т хэрэгжилтийг хариуцан ажиллахаар захирамжилжээ.

**Дүгнэлт:** Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим ТАХ нь тооцоо судалгаан дээр бүрэн төлөвлөгдөж эхлээгүй, санхүүжилт удааширсан зэргээс төслүүд хугацаандаа хэрэгжиж дуусахгүй удаашрах, ТАХ-ний үр дүнг бууруулах, зээлийн хөрөнгийг буцаан татуулах, үр ашиггүй зарцуулах үндэслэл болж байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. НИТХ, НЗД нь урт дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлахад тогтвортой байдлыг хадгалаагүй, өмнө батлагдсан арга хэмжээний залгамж чанарыг алдагдуулсан, хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтөд нийцүүлээгүй, нийслэлийн эрх бүхий байгууллагуудын замын хөдөлгөөн зохицуулах, ачааллыг бууруулах чиг үүрэг, үйл ажиллагаа нь харилцан уялдаагүй зэргээс зорилт арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
2. Автозамын ачааллыг бууруулахаар төлөвлөсөн метро, BRT, агаарын дүүжин тээвэр, олон түвшний огтлолцол зэрэг томоохон төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, нийтийн тээвэр хүрэлцээгүй, парк шинэчлэлт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.
3. Замын хөдөлгөөний зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээрх зорилт арга хэмжээг тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөний хүрээнд төлөвлөж, улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээлийн эх үүсвэрийг бүрэн ашиглаагүй байна.
4. Хот төлөвлөлт болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн харилцан уялдааг хангаж, газар олголтыг төлөвлөлтөд нийцүүлэн, шат шатны хяналтыг цаг тухай бүр хэрэгжүүлсэн бол 2012-2022 онд газар чөлөөлөлтөд 246,528.4 сая төгрөг зарцуулах шаардлагагүй байжээ.
5. Нийслэлийн бүтэц, зохион байгуулалтаар замын хөдөлгөөнийг зохицуулах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн боловч хүн амын болон тээврийн хэрэгслийн өсөлт, түүнийг дагасан иргэн, аж ахуйн нэгж, автомашины төвлөрөл, сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ зэрэг улсын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн хяналтгүй өсөлтүүдээс шалтгаалж хэрэгжилтийн үр дүнг бууруулж байна.

---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

---

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч  
/Д.Сумъяабазар/-д:**

1. Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээр бодлогын баримт бичиг, зорилт, арга хэмжээ төлөвлөх, батлахдаа төрийн үйл ажиллагааны залгамж халаа, тогтвортой байдлыг хадгалах;
2. Холбогдох мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хэрэгжүүлэх;
3. Замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг тооцож, үр дүнд хяналт-шинжилгээг хэрэгжүүлэх.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
Жанжин Д. Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022 о. 12. 08 № 03/6534  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ

Нийслэл дэх Төрийн Аудитын газраас  
"Нийслэлийн замын хөдөлгөөний бодлого, төсвийн  
зарцуулалтын үр дүн"-д хийсэн НТАГ-2022/46-ШТА-ГА  
тайлангийн төсөлтэй танилцаж саналаа хавсралтаар  
хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



D:\2022 он\Alban bichig\TG-A5.docx  
11023005061

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО, ТӨСВИЙН  
ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮНД ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН  
ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

1. Автозамын ачаалал бууруулах чиглэлээр метро, BRT, агаарын дүүжин тээвэр, олон түвшний огтлолцол зэрэг томоохон төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 2012-2021 онд нийт 157 автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. Автозамын ачаалал бууруулах чиглэлээр метро, BRT, агаарын дүүжин тээвэр, олон түвшний огтлолцол зэрэг томоохон төсөл арга хэмжээ хэрэгжээгүй гэсэн дүгнэлттэй санал нийцэхгүй байна.

1. Метро (LRT – тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл)

- НИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 27 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх үүрэг бүхий "Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК-ийг үүсгэн байгуулж, дүрмийг баталсан.
- Засгийн газрын хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 31 дүгээр тэмдэглэлээр нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл"-ийн ажлыг хэрэгжүүлж, 2022 онд багтаан эхлүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиралч Д.Сумъяабазарт даалгасан.
- НИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр тэмдэглэлээр "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл"-ийг дэмжих тухай хэлэлцээд уг төслийн ажлыг 2022 онд багтаан эхлүүлэхийг Нийслэлийн Засаг даргад үүрэг болгосон.
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/959 дүгээр захирамжаар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангахад 19,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9,600.0 сая төгрөгийн 2022 онд санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээг "Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК-д эрхийг нь шилжүүлэн, зохион байгуулж байна.

2. BRT (Тусгай замын автобус төсөл)

- Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтын ажиллагааны хүрээнд стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах, Засгийн газрын төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, шинэ технологи, стандарт, менежментийн арга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", 2020 оны 24 дүгээр тогтоолоор "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" дүнд хугацааны бодлогын баримт бичгүүд тус тус батлагдсан.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд үндэслэн "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" дүнд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулсан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

3. Замын хөдөлгөөний зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээр зорилт, төсөл, арга хэмжээг оновчтой, зөвхөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлж, улс, орон нутгийн төсөв болон гадаадын эзэл, хандивын хөрөнгийн эх үүсвэрийн боломжийг бүрэн ашиглаагүй байна.

Нийслэлийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн тухайн жилийн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын эзэл, тусламжийн хөрөнгийг ашиглаж байна.

Замын хөдөлгөөний зохицуулалт, ачааллыг бууруулах чиглэлээр гадаадын эзэл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 333.9 сая ам.долларын төслийг хэрэгжүүлж байна. Үүнээс БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөл", "Бармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл", "Туул гол дэлгүүрх байгуулахын 321 үйл болон Сонгосолонгийн 289.4 у/м төмөрбетон гүүрийг шинээр барих төсөл", "Гачууртын уулаараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн төсөл" зэрэг нь хэрэгжиж дууссан.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нукан гарц барих төсөл", БНФУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл-1", Японы Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн сангийн буцалтгүй тусламжаар "Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл", Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Улаанбаатар хотын тогтвортой зам, тээврийн төсөл" тус тус хэрэгжих шатандаа байна.

Цаашид Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хамтран "Улаанбаатар хотод олон түвшний уулзвар байгуулах төслийн ТЗҮ боловсруулах төсөл", АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр түгжрэлийг бууруулахад чиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн нарийвчилсан тооцоо судалгаа болон зураг төслийг боловсруулах "Жижиг зардлыг санхүүжүүлэх төсөл"-ийг тус тус хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

---

## САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

---

НЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 03/6534 дугаар албан бичгээр аудитын тайлангийн төсөлтэй танилцан, санал ирүүлсэн.

**“Санал 1-3”-ын тайлбар:** Саналд дурдсан асуудлууд нь аудитад хамрагдах хугацаа буюу 2012-2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бодлогын баримт бичигт Метро НЗД-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, BRT /тусгай замын автобус төсөл/, Агаарын дүүжин тээвэр зэрэг нь МУЗГ, НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан ч дээрх онуудад хэрэгжээгүй.

Харин Алсын хараа-2050 баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээрх арга хэмжээнүүд тусгагдсан талаар аудитын тайланд дурдсан бөгөөд саналын агуулга нь 2021 оноос хойш хэрэгжиж байгаа талаар дурдсан тул хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.